

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ  
“ШИНЭ БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

/2014 оны жилийн эцсийн байдлаар/

2014.11.24.

Булган аймгийн Засаг даргын 2013-2016 оны хөтөлбөрийн үндсэн зорилго нь Шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын бодлого чиглэлийг хэрэгжүүлж, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, орон нутгийнхаа хөгжлийн төлөө нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хийхш шинэчлэлийн үзэл санаанд нэгдэн ажилтай орлоготой, эрдэм боловсролтой, эрүүл чийрэг, эрх чөлөөтэй, аюулгүй орчинтой “Шинэ Булган”-ыг бүтээн байгуулахад оршино.

### **НЭГ. АЖИЛТАЙ ОРЛОГОТой БУЛГАНЧУУД**

“ХҮНИЙ ХӨГЖИЛ”-ийг дэмжиж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэн эдийн засгийг солонгоруулж олон тулгуурт өөрийгөө тэтгэх чадвар бүхий эдийн засгийн тогтвортой салбаруудыг хөгжүүлж, дэд бүтцийн хөгжлийг түргэтгэн хөдөлмөрийн зах зээлийг хангаж төр, ТББ, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1.1.** Хүн амын үндсэн хэрэгцээг хангахуйц, өөрийгөө тэтгэх чадвар бүхий эдийн засгийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: Хүн амын амьжиргааны түвшин дээшилж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 6,4 сая төгрөгт хүргэнэ.

Аймгийн цогц бодлогийн 5 салбар хүрээний 15 зорилгийн 49 арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр нийт арга хэмжээг биелүүлж ажиллахын тулд нийт 463 зорилтыг хэрэгжүүлдэг ба 2014 онд өссөн дүнгээр 50 хувь, тухайн онд хийсэн ажлын дүн 88.0 хувиар биелсэн байна. Энэ оны хэрэгжилтийн үр дүнг тооцохоор ажиллаж байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 286.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 115.8 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 4.8 сая төгрөг болж өмнөх оноос 0.7 сая төгрөг буюу 117 хувиар өссөн байна.

**/Тухайн жил 95.0 хувь/  
/Өссөн дүнгээр 48.75хувь/**

#### **Хөдөө аж ахуйн салбарт:**

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлж, иргэдийг экологийн цэвэр эрүүл хүнсээр хангана.

**Зорилт 1.2.** Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно.

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа эргэлтийн талбайг 100 хувь ашиглаж, нэгжийн ургацын хэмжээг нэмэгдүүлэн, дотоодын хэрэгцээг гурил, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлаар 100 хувь, жимс жимсгэнээр 10 хувь хангана.

Аймгийн хэмжээнд аж ахуйн нэгж иргэдийн эзэмшилд 81.8 мянган га талбай байдаг. Үүний 66 мянган га талбайг эргэлтэнд оруулж нийт талбайн 81.5 хувийг ашиглаж байна. 2004-2012 онд 76,0 га усалтын системийг засварлан, нийт үр тарианы 502 га, жимс жимсгэний 140 га талбай бүхий 7 системийг шинээр барьж байгуулсан. Одоогоор 263 га-д үр тариа, 372 га-д жимс жимсгэнэ, 642 га-д төмс, 324 га-д хүнсний ногоо, нийт 1600 га-д усалгаатай тариалагдсан байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.3.** Мал үржлийн ажил үйлчилгээг сайжруулж, төв суурингийн ойролцоо эрчимжсэн аж ахуйнуудыг байгуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар малын тоон өсөлтийг тогтворжуулж, салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх тоо хэмжээ 15 хувьд хүрч, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт 10 хувь нэмэгдэнэ.

“Сэлэнгэ” үүлдрийн үхрийг сонгон үржүүлэх бүс нутгийг тогтоож, “Инновацын төсөл хэрэгжүүлж байна. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналт үйлчилгээний дор тусгайлан хариуцан маллаж үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөтлөн явуулах зорилгоор аймгийн Засаг даргын А/263 дугаар захирамжийг гарган Могод, Гурванбулаг, Бүрэгхангай, Дашинчилэн сумдыг сонгон авч зөвлөмж чиглэлийг хүргүүлж, зохион байгуулж байгаа ажилтай танилцаж, сумдын засаг дарга, МЭҮТ-ын мэргэжилтнүүдтэй уулзаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, санал солилцов. Эдгээр сумд 2015 оны орон нутгийн хөгжлийн сан болон малчдад олгож буй урамшууллын орлогоос төвлөрч буй хөрөнгөөс санхүүжилтийг тусгахаар төлөвлөөд байна. Сэлэнгэ, Бугат, Хангал, Булган, Хутаг-Өндөр, Рашаант, Баян-Агт, Могод, Тэшиг сумдад сүүний үнээний фермерийн 11, махны үхрийн фермерийн 3, хонины аж ахуйн чиглэлээр 1, гахайн 2, загас үржүүлэх чиглэлээр 1, шувууны аж ахуйн чиглэлээр 1, нийт 19 иргэн, аж ахуй нэгжийн төсөлд 634.8 төгрөгийн зээлийн дэмжлэгийг жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгов.

**/Тухайн жил 90 хувь/**

**/Өссөн дүнгээр 40 хувь/**

**Зорилт 1.4.** Мал эмнэлгийн үйл ажиллагааг технологит хугацаанд нь чанартай хийж, халдварт өвчнийг тандан, шуурхай оношилж, паразиттах өвчний гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, малыг эрүүлжүүлнэ.

Хүрэх үр дүн: Малын халдварт өвчний гаралтыг 5 хувь, паразиттах өвчний гаралтыг 3 хувь бууруулна.

Малаас хүнд халдварладаг бруцеллёз, сүрьеэ, лейкоз өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр бодлого гарган хэрэгжүүлж байна.

Халдварт өвчнийг шуурхай оношлох, тандалт хийх замаар илрүүлж, мал амьтны халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь хийлээ. Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 693.3 мянган толгой мал хамрагдахаас 638.3 мянган толгой мал хамрагдаж төлөвлөгөөний биелэлт 92.1 хувьтай байна. 2014 онд нийт сумдын 41500 малын дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулахаас одоогоор 40336 мянган мал дээж хамрагдаж 97,1 хувийн гүйцэтгэлтэй байна

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.5.** Хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэгт тулгуурлан хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүнд анхан шатны тордолт, ангилалт хийх, борлуулах сүлжээ бүхий Хөдөө аж ахуйн биржийг сумдад бий болгоно.

Хүрэх үр дүн: Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр хангагдана.

Малчдад зориулсан “Хоршооны сургалт”-ыг 20 хоногийн хугацаатай бүх суманд зохион байгуулж, судалгаа, санал асуулга авлаа. Орхон, Булган, Дашинчилэн сумдын малчдын зөвлөлгөөнд оролцож, хоршооны зохион байгуулалтын зарчим, хоршооны хууль, малчдын хоршоо байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар сургалт явуулж, мэдээлэл өгөв. Сумдын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 50 гаруй хүмүүс сонгогдон түүхий эд нийлүүлэх гэрээг Улаанбаатар, Дархан, Орхон аймгуудын үйлдвэрүүдтэй байгуулан арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эдээ нийлүүлэн ажиллаж байна. Сумдын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар, хоршоод, малчдад зориулсан сургалтыг зохион байгуулж, семинар өгч түүнд 150 гаруй хүн хамрагдав. Оны байдлаар 110 хоршоод татварын хэлтэст бүртгэлтэй байгаа нь өмнөх онтой харьцуулахад 37.0 хувиар өссөн байна.

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт:**

Орон нутгийн түүхий эд, нөөцөд түшиглэсэн дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, бүтээгдэхүүний

өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааны салбарын өсөлтийг дэмжиж, ажлын байрыг бий болгоно.

**Зорилт 1.6.** Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг хөрөнгө санхүү, зээлийн бодлогоор дэмжинэ.

Хүрэх үр дүн: Хөнгөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо өсч, шинээр жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ бий болж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

2014 оны 11 сарын байдлаар аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”-аас нийт **88** бизнес төсөл **2.5** тэрбум төгрөг, Хөдөлмөрийн яамны ЖДҮДС- аас **3** төсөл **376.0** сая төгрөг, “Сум хөгжүүлэх сан”- гаас 2011-2014 оны эхний хагас жилийн байдлаар нийт **931** төсөлд 5.0 тэрбум төгрөгний зээл олгож төсөл хэрэгжиж байна.

Арьс ширний урамшуулалд 7 сумын 326 малчин өрхийн 5121 арьс ширэнд 21,6 сая төгрөгийн урамшуулал, давхардсан тоогоор 110 хоршооны 4656 малчин өрхийн 1.209.366 тн хонины ноос, 773 кг тэмээний ноос нийт 1.210.139 тн ноосонд урамшуулал олгохоор материалыг нэгтгэж Мал хамгаалах санд хүргүүлээ.

Аймгийн 7 гурилын үйлдвэр, цехүүд үйлдвэрийн үндсэн түүхий эд 12063,62 тн улаан буудай нөөцөлж, үндэсний томоохон гурилын үйлдвэрүүдэд 7151.31 тн улаанбуудай нийлүүлж, Тариалан эрхлэлтийг дэмжих сан 730.2 тн улаанбуудай нөөцлөн авч, газар тариалан эрхлэгчид улаанбуудайн урамшууллын материалаа бүрдүүлж байна.

“Гурилын үнэ тогтворжуулах” хөтөлбөрт хамрагдахаар 5 аж ахуйн нэгж саналаа өгснөөс Сэлэнгэ сумын ИНТОСЭ, Дашинчилэн сумын Муку ХХК-ууд 200 сая төгрөгийн зээл авч буудай нөөцлөж авлаа.

Аймгийн хэмжээнд “Заан хүж” сургалтын төв, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент төслүүд бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн 14 мэргэжлийн холбоод нь салбарт ажиллагсадынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.

***/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 64,0 хувь/***

**Зорилт 1.7.** Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, худалдаа, нийтийн хоолны газруудын эрүүл ахуйн орчин нөхцлийг сайжруулж, шударга өрсөлдөөнийг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Хүрэх үр дүн: Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газрууд төрөлжин хөгжиж үйлчилгээний орчин нөхцөл сайжирна.

“Булган аймгийн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх бодлого”- ийг боловсруулж аймгийн ИТХ-ийн 2014 оны 66-р тогтоолоор батлуулж, тэргүүн ээлжинд дэмжин хөгжүүлэх жижиг, дунд үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тогтож, хөгжүүлэхэд шийдвэр гаргах үүрэг бүхий “Салбар дундын зөвлөлдөх зөвлөл, ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг”- ийг аймгийн Засаг даргын захирамжаар томилуулж, ажлын хэсгийн чиг үүрэг, боловсруулах ТЭЗҮ- ийн чиглэлийг батлуулав. Хутаг- Өндөр суманд жишиг сумын үйлдвэр технологийн парк байгуулахаар ТЭЗҮ-ийг Монголын ложистогийн холбоотой хамтран боловсрууллаа.

Хялганат тосгон үйлдвэр технологийн парк байгуулахаар газрын байршлыг сонгож, үйлдвэрлэлийн бүсэд байрлах үйлдвэр аж ахуйн нэгж, иргэдийг зохион байгуулалтад оруулж, “Хялганат энерги” ХХК “Цэвэршүүлсэн модон хавтан”-гийн үйлдвэрийн Тайвань тоног төхөөрөмж суурьлуулж байна.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ суманд “Сэлэнгэ ахай гүн” ХХК, Хялганат тосгонд “Баруун тайга” ХХК, Хишиг- Өндөр суманд “Тайж манлай” ХХК- ууд орчин үеийн шийдэл бүхий үйлчилгээний газрууд ашиглалтад орууллаа. “Булган Мээж” ХХК нь халуун усны газартаа капитал засвар хийж халуун усны үйлчилгээний стандартын шаардлагад нийцсэн ажил үйлчилгээг иргэддээ үзүүлж байна. “Булган Анар” ХХК-нь үйл ажиллагаагаа өргөжүүлж караоке вип өрөө, үсчин, гоо сайханы салон, сауны үйлчилгээ нээлээ.

Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон, Сайхан, Хангал, Тэшиг сумд орон нутгийн өмчийн барилга обектийг засаж тохижуулан жижиг бизнес, ахуйн

үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлттэй үнээр түрээслэж 60 гаруй иргэнийг тогтвортой ажлын байртай болгож үйл ажиллагаа нь хэвийн явж байна.

Дашинчилэн, Могод сумд хувийн хэвшлийн хөрөнгөөр Ахуйн үйлчилгээний төв барьж, Хялганат тосгон Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент төслөөр орон нутгийн өмчит барилга объектийн 1 давхарт засвар хийлгэж ахуйн үйлчилгээний төв бий болгохоор төслийн нэгжтэй тохирч зураг төсвийг хийлгэж, Хутаг- Өндөр сум энэ онд шинээр ашиглалтад орсон Халуун усны дэргэд 2 өрөөнд ахуйн үйлчилгээний шинэ цэг гаргахаар ажиллаж байна.

Булган сумын 5 дугаар багт “Байгаль хамгаалах сан”-гаас “Сити ОО”, гутал засвартай барьж ашиглалтад өглөө. Баян- Агт сум “Орон нутгийн хөгжлийн сан”-аас хөрөнгө гаргаж “Бүтээлч” иргэдийн бүл ахуйн үйлчилгээний цэгийн байрыг засаж байна.

Ахуйн үйлчилгээг дэмжиж сум хөхгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас нийт 48 төсөлд 728.1 сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлж үйл ажиллагаа нь амжилттай явж 46 байнгын ажлын байр шинээр бий болж 26 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг ахуй үйлчилгээний чиглэлээр дэмжин Хангал, Орхон, Булган сумын 13 иргэнд 13,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Баяннуур, Орхон, Тэшиг, Сайхан, Хангал, Баян- агт сумдад 136.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх нээлттэй тендер зарлаад байна.

Ахуй үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтад 98 иргэн хамруулж, Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийн захиалгаар 41 иргэн ажлын байраар хангагдлаа.

Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 54 тоот тогтоолоор батлуулж, аймгийн хэмжээнд барилгын материалын түүхий эд олборлох нөөц газрын судалгааг гаргалаа. Булган сумын барилгын материалын үйлдвэрлэлийн бүсэд Орхон аймгийн “Билгүүнжин” ХХК - ны тоосго, явган замын хавтан, барилгын ханын бетон хийцийн үйлдвэр байгуулах төсөлд 1.4 га газар, Улаанбаатар хотын “ОМДА” ХХК бетон зуурмагийн үйлдвэр, чулуу бутлан ангилах үйлдвэр, хүрмэн гулдмайн үйлдвэр байгуулах төсөлд 1 га газрыг тус тус олгож “Билгүүнжин” ХХК нь тоног төхөөрөмжөө суурьлуулж үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлж, Булган сумын “Нүнжигт өргөө” ХХК нь хүрмэн чулуун блок үйлдвэрлэж эхэллээ. Орхон сумын Сээрийн үйлдвэрлэлийн бүсэд “Өрнөлт дүгнэн хоршоо”- керамик тоосгоны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурьлуулж тоосго үйлдвэрлэж эхэллээ. Хайрган болон хүрмэн блок, вакум цонх, модон материал үйлдвэрлэлийн чиглэлээр аймгийн хэмжээнд 67 жижиг цех үйл ажиллагаа явуулж байна. Булган сум сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас барилгын дүүргэлтийн болон даац, өнгөлгөөний тоосго үйлдвэрлэх 5 төсөлд 150.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

“Булганыхан” нутгийн зөвлөлийн уулзалт, “Төр иргэний нийгмийн байгууллагын түншлэл -2014 форум”- ын “Ажилтай орлогтой Булганчууд”, “Бизнесийн салбарын салбар” хуралдаануудыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, төр, иргэний нийгмийн зөвлөл байгууллаа. “Төслийн удирдлагын орчин үеийн чиг хандлага” “Компаны засаглалыг хөгжүүлэх”, “Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо, хүнсний байцаагч, үйлдвэрлэгчдийн хамтын үүрэг, оролцоо” сургалтыг зохион байгууллаа. Хоол үйлдвэрлэлийн салбарт ажиллагсадын мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд зохистой дадал нэврүүлэх нь сэдэвт сургалтыг төрөлжүүлэн зохион байгуулж, 2014 оны аймгийн “Аварга тогооч, зөөгч, нарийн боовчин” шалгаруулах ур чадварын уралдааныг амжилттай зохион байгууллаа. Аймгийн Үсчин гоо сайханчдын холбоо нь 2014 оны шилдэг үсчин, гоо сайханч шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнээ амжилттай зохион байгуулж салбарт ажиллагсадынхаа ур чадварыг нь тодорхойлж үйл ажиллагаандаа дүгнэлт хийлээ. Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй Монгол-Орос-Хятадын ХАҮТанхимуудын 10 дахь удаагийн Нэгдсэн Чуулга уулзалтад аймгийн ХАҮТ оролцлоо.

**/Тухайн жил 82,5 хувь/**

**Зорилт 1.8.** Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нэмэгдэж, хүнсний баталгаат байдал сайжирна.

“Баяндаш хайрхан” ХХК -нь “Мал мах бэлтгэлийн нэгдсэн төв” 80 тн-ий хөргүүртэй агуулахыг ашиглалтад оруулж аймгийн 2014, 2015 оны нөөцийн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн нийлүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Иргэд хөдөлмөрөөрөө хоршон нийлж өлөн боловсруулах цех ашиглалтад орууллаа. “Буман сүхэс” ХХК сум хөгжүүлэх сангаас 10.0 сая төгрөгийн зээл авч хиамны цех тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Булган сумын 4 багт улсын төсвийн 100.0 сая төгрөгний хөрөнгөөр мал нядалгааны цэг, 3 тн-ы багтаамжтай гүн хөлдөөлтийн агуулах барих барилгын ажил, тоног төхөөрөмж суурьлуулах ажил хийгдлээ. Дэд бүтцийг нь шийдвэрлэхээр 70.0 сая төгрөгийн төсөв боловсрууллаа.

“Энэ онд аймгийн төвд “Хустай бекери”, “Бөмбөөлэй”, “Нандин” нарийн боовны цех шинээр байгуулагдаж, “Арвайн эхлэл” ХХК нь “Сум хөгжүүлэх сан”-аас 20.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл авч зориулалтын үйлдвэрийн байртай болж, Цагаан далай сан”-ийн дэргэдэх “Ногоон өгөөж бүл” сүү боловсруулах цех шинээр байгуулан ажиллуулж байна. “Өрмөгтэй” ХХК нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 40.0 сая төгрөгийн зээл авч гурилын үйлдвэрийн засвар тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн бөгөөд 2015 оноос гурил үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байна. “Орхон мандал” ХХК нь “Гурилын үнэ тогтворжуулах” хөтөлбөрт дахин хамрагдахаар хүсэлтээ ҮХААЯ- д уламжилж, Тэшиг сумын “Шинэ амжилт” ХХК нь ЖДҮДС- аас шинээр гурил, тэжээлийн үйлдвэр байгуулахаар зээл авлаа. ҮХААЯ- аас хөнгөлттэй үнээр 2 тэжээлийн үйлдвэр олгосны 1- ийг аймгийн нөөцийн газарт өгч, нөгөө нь Дашинчилэн сумын “Муку” ХХК - ий хүсэлтийн дагуу өгөхөөр ҮХААЯ-д хүсэлтийг уламжиллаа. Энэ жил 168 га-д хөх тариа, 233.3 га-д халтар арвай, 56 га-д бог будаа тариалсан нь өнгөрсөн онтой харьцуулахад хөх тариа 99 га-аар буурч, халтар арвай 33 га-аар, бог будаа 35 га-аар нэмэгдлээ. “Сайхан харзтай” ХХК-ийн Бог будааны үйлдвэрлэлийг дэмжиж 40.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэний үр дүнд бог будаа тариалалтыг 17 га-р нэмэгдүүллээ. Хангал, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумд СХС-аас халтар арвай, бог будааны тариалалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж 35.0 сая төгрөгийн зээл олгосоноор тариалалтыг нэмэгдүүлэхэд бодитой дэмжлэг боллоо. Аймгийн хэмжээнд сүү боловсруулах 1 томоохон үйлдвэр, 7 жижиг цех ажиллаж байна. Сүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулахаар “Сум хөгжүүлэх сан”- аас эрчимжсэн фермерийн үйл ажиллагааг дэмжиж нийт 66 төсөлд 401.4 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгож дэмжин ажиллаж байна. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас Булган, Дашинчилэн, Орхон, Рашаант сумдад сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх 4 төсөлд 120.0 сая төгрөгийн зээл олгож төсөл хэрэгжиж байна. “Сум хөгжүүлэх сан”-гаас хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах чиглэлийн 124 төсөлд 499.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүллээ.

**/Тухайн жил 93 хувь/**

**/Өссөн дүнгээр 42,0 хувь/**

**Зорилт 1.9.** Аж ахуйн нэгжийг зах зээлийн хэрэглээгээр дэмжих, борлуулалт ашиг орлогыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Иргэдэд үндэсний болон орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх сэтгэл зүй төлөвшиж, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.

“Хангайн бүсийн түншлэл Хөвсгөл - 2014” үзэсгэлэн худалдаанд 6 сумын 30 гаруй иргэн, хоршоо, аж ахуйн нэгжийг зохион байгуулж амжилттай оролцуулж туршлага судлууллаа. “Чанар ба цагаан сар” үзэсгэлэн худалдаанд 10 сумын 61 иргэн ААН-үүд 190 нэрийн 42,6 сая төгрөгийн бүтээгдэхүүнээр оролцож, Дэлхийн стандартын өдрөөр “Үйлдвэрлэлээ дэмжигч” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 15 аж ахуйн нэгж иргэн 65 нэрийн бүтээгдэхүүнээр оролцож Булган сумын иргэдэд хямд үнэтэй хүнсний бүтээгдэхүүнээр үйлчиллээ. “Аварга тогооч, зөөгч бармен, нарийн боовчин” шалгаруулах ур чадварын уралдаан, хоол, нарийн боовны

үзэсгэлэн, Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээ, “Баялаг бүтээгчид - 2014” үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Аймгийн ХАҮТ-ын гишүүн аж ахуйн нэгжүүд, Зах зээл бэлчээрийн удирдлагын менежмент төслийн гишүүн бүл”-ийн төлөөллүүд ОХУ-ын Манжуур хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн яармагт оролцож туршлага судаллаа. Хялганат, Тэшиг, Хишиг - Өндөр, Хутаг-Өндөр сумдуудад “Хөдөлмөрийн яармаг” үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа. “Төслийн удирдлагын хөгжлийн хүрээлэн”, Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв” зэрэг ТББ-тай хамтран дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу өрсөлдөх чадвар болон төслийн удирдлагын менежментийг хөгжүүлэх чиглэлээр сургалт мэдээлэл, судалгааны ажлуудыг хийж байна.

**/Тухайн жил 100,0 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.10.** Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, хэрэглэгчийг чанартай аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал хэмжилзүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг сайжруулна.

Хүрэх үр дүн: Стандартчилал тохирлын үнэлгээ, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хуулийн хэрэгжилт сайжирна.

Стандартчилал хэмжилзүйн хэлтэс нь үйл ажиллагаандаа “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-2010” олон улсын стандартыг нэвтрүүлж байгууллагын Чанарын удирдлагын тогтолцооны БАТЛАМЖ авлаа. Төрийн 28 байгууллагын удирдах ажилтан менежерүүд, Татварын хэлстийн хамт олонд Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартаар сургалт зохион байгууллаа. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийн стандартуудаар эмхтгэл бэлтгэж 35 байгууллагад хүргүүлж, **“Стандарт ижил тэгш өрсөлдөх боломжийг бий болгож байна”** уриаг сурталчилан таниулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Холбогдох стандарт, дүрэм журмын дагуу тохирлын үнэлгээг явуулж стандартын шаардлага хангасан 13 иргэн, аж ахуйн нэгжийн 45 нэрийн бүтээгдэхүүн, 190 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн 10 нэрийн 202 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож ажил үйлчилгээг нь баталгаажууллаа. Стандартын салбар сангаар 500 гаруй иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад үйлчилгээ үзүүллээ.

Барилгын материалын туршилт сорилын лаборатори байгуулж, хэрэглэгдэх шахагч машин 1 ш, ком шүршүүр 1ш, конусын суулт тодорхойлогч 1 ш, бетон сорьцын хэв 2 ширхэгийг аваад байна. Зураг төсөл эрдэм шинжилгээний институтаас зохион байгуулсан барилгын материалын лаборант нарыг бэлтгэх сургалтанд мэргэжилтийг хамрууллаа.

**/Тухайн жил 80.0 хувь/  
/Өссөн дүнгээр 40.5 хувь/**

**Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.**

**Зорилт 1.11.** Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх арга замыг судлан тогтоож, жуулчдын сонирхол, хэрэгцээг хангахуйц арга барилыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Булган нутагт ирэх жуулчдын тоо нэмэгдэж, ногоон эдийн засгийн хөгжилд бодитой ахиц гарна.

Байгаль хамгаалах сангаас 40,0 сая төгрөгийг экотуризмыг хөгжүүлэх зорилгоор төлөвлөж, аймгийн аялал жуулчлалын бодлогыг батлуулан хэрэгжүүлж байна. Аялал жуулчлалын салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг анх удаа зохион байгуулж, аймгийн аялал жуулчлалын холбоо төрийн бус байгууллагыг байгууллаа.

Эвент арга хэмжээг тогтмолжуулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Сайхан сумандах “Айрагны баяр”, Хутаг-Өндөр сумандах “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг зохион байгуулж тус арга хэмжээнүүд гадаад дотоодын жуулчдыг хамрууллаа.

Усан аялалын нөөц тодорхойлох, маршрут тогтоох судалгааны ажлыг аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэгээр гүйцэтгүүлж цаашид усан аялалыг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан гаргалаа.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 43,3 хувь /**

**Зорилт 1.12.** Байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, рашаан сувилал, дэд бүтэц зэрэг давуу талаа түшиглэн аялал жуулчлалын маршрут гаргаж, салбарын үйлчилгээний чанар стандартыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн:

-*Байгальдаа ээлтэй, аяллын тав тухтай орчин бүрдэнэ.*

-*Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.*

“Хулжийн рашаан”, “Хануй”, “Цагаан гол” , “Их булаг”, “Хунт” зэрэг рашаануудыг түшиглэсэн аялалын 5-н чиглэл, Байгалийн үзэсгэлэнт газар, ТСҮХДЗ-ийг холбосон 5 чиглэлийн маршрутыг гаргаж хөтөлбөрт орууллаа.

Мөн Хануй, Цагаан голын ай савд үйл ажиллагаа явуулж буй амралтын газар рашаан сувилалын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж нийт 40 газар олгогдсон хуулийн этгээдээс 7 аж ахуйн нэгж 33 иргэнд газар олгогдон үйл ажиллагаа явагдаж байгаатай танилцаж цаашид байгальд ээлтэй рашаан сувилалыг тогтвортой хөгжүүлэх стратеги боловсруулах тодорхой саналуудыг боловсруулахаар ажиллаж байна. Мөн аялал жуулчлалын веб сайт, танилцуулга каталоги гаргах, газрын зургийг шинэчлүүлэх ажлыг эхлүүлээд байна.

**/Тухайн жил 86,6 хувь/  
/Өссөн дүнгээр 40 хувь/**

**Зорилт 1.13.** Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: *Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг багасгана.*

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Бугат суманд сум хөгжүүлэх сангаас 10 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам талбай, амрагчдад зориулсан байрыг бариад байна. Мөн аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгах зорилгоор Орхон суманд “Ханнамсан” ХХКомпани НАМСАН, “Оросын булаг” зэрэг амралтын газар тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ суманд “Мөсний баяр”, Бугат суманд “Цасны баяр” –ын арга хэмжээнүүдийг уламжлалт соёлын арга хэмжээнүүдтэй уялдуулан уламжлал болгон зохион байгуулахаар ажиллаж байна. Хутаг-Өндөр, Бугат, Бүрэгхангай, Орхон, Могод, Хишиг-Өндөр, Хангал, Хялганат зэрэг өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган мөсний шагайн тэмцээнийг зохион байгуулсан.

**/Тухайн жил 80.0 хувь/  
/Өссөн дүнгээр 37,5 хувь/**

**Дэд бүтцийн салбарт:**

***Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын хөгжлийг эрчимжүүлж эрүүл аюулгүй тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.***

**Зорилт 1.14.** Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг сайжруулж, “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн замын ажлыг дуусгаж, аймаг, сумдын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна.

Хүрэх үр дүн: *Аймгийн авто замын үрт нэмэгдэж, авто зам, замын байгууламжийн нөхцөл, нийтийн тээврийн үйлчилгээ сайжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.*

Улсын төсвийн хөрөнгөөр Уньт-Хутаг-Өндөр-Намнан чиглэлийн 88 км, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган сумын гэр хороололд 4,9 км нийт 92,9 км хатуу хучилттай авто зам шинээр барьж, нийтийн эзэмшлийн 5 газарт автомашины зогсоол шинээр байгуулж, замын хөдөлгөөнийг нээв.

Шуудан үйлчилгээний газраас Дашинчилэн, Бугат, Гурванбулаг сумдад шуудан, зорчигч тээврийн үйлчилгээний шинэ чиглэл нээж, үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний үр дүнд аймгийн төвтэй Дашинчилэн, Бүрэгхангай, Орхон, Хишиг-Өндөр, Могод, Гурванбулаг, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг 10 сумд зорчигч, шуудан тээврийн үйлчилгээгээр холбогдоод байна.

**/Тухайн жил 74,7 хувь/**

**/Өссөн дүнгээр 54,0 хувь/**

**Зорилт 1.15.** “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.

Хүрэх үр дүн: Иргэдийн ая, тухтай амьдрах орчин, нөхцөл сайжирна.

13 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна.

“Сумын төвийн шинэчлэл” төсөлд манай аймгийн Хутаг-Өндөр сум хамрагдаж, Улаанбаатар хотын “Эрхэт наран” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Төслийн хүрээнд 4310 дулаан, цэвэр усны шугам, 2180 бохирын шугам болон бохирын систем, халаалтын барилгын засвар, сумын төвийн тохижилтын ажлууд хийгдэж байна.

“Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж”-МОН/13/302 төслөөр Бүрэгхангай, Тэшиг суманд дулаан, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, усан сан, насос станц, бохир ус цэвэрлэх байгууламж, нийгмийн үйлчилгээний барилгуудын дотор сантехникийн угсралтын ажил хийгдэж байна.

“Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төслөөр Могод сумын халаалтын зуух, гадна дулааны шугам сүлжээг шинэчлэн сольсон. Үүний үр дүнд шинээр 2 сумыг нэгдсэн халаалтад шилжүүллээ.

**/Тухайн жил 70 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.16.** Аймгийн төв, сум суурин газрын хот байгуулалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотой хийж, хүн амын өсөлт, хэрэгцээтэй уялдуулан, 1000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд амины болон нийтийн орон сууцны шинэ хороолол барих, түүнтэй холбоотой дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.

Хүрэх үр дүн: Амины болон нийтийн орон сууцны шинэ хорооллыг байгуулж, орон сууцны хангамж, нөхцөл сайжирна.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Аймаг бүрт 1000 айлы орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Булган суманд нийтдээ 422 айлын орон сууц, орон сууцны цогцолбор барих ажлыг эхлүүлж, Цагдаагийн газрын ажилчдын 30 айлын орон сууц ашиглалтад орлоо.

Тэшиг, Хишиг-Өндөр суманд 8 айл, Рашаант, Хутаг-Өндөр суманд 12 айлын орон сууц барих ажил эхлээд байна. Сайхан сум 8 айлын орон сууц барих ажлын зураг төсвийг хийлгэсэн.

Баян-Агт сум 10 айл, Орхон суманд 28 айл, Сэлэнгэ сум 4 айлын амины сууц барьсан.

**/Тухайн жил 97,5 хувь/**

**/Өссөн дүнгээр 52.8 хувь/**

**Зорилт 1.17.** Инженерийн шугам сүлжээний системийг өргөтгөж, дулаан, цахилгааны найдвартай эх үүсвэрүүдийг шинээр бий болгоно.

Хүрэх үр дүн: Инженерийн шугам сүлжээний хүчин чадал хангамж сайжирч, найдвартай ажиллагааны түвшин дээшилнэ.

Хүүхэдзалуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн, Булган сумын 6-р багийн “Д” хэсгийн амины орон сууцны хороолол, Шүүхийн халаалтын тогооноос Булган буудал хүртэлх инженерийн шугам сүлжээ, “Хас” банкнаас “Хаан” банк хүртлэх ариутгах татуургын шугам, халаалтын 4 дүгээр зуухнаас 3 дугаар багийн А,Б хэсгийн айл өрх, халаалтын 3 дугаар зуухнаас 1,2 дугаар багийн А хэсэг, 6 дугаар багийн А хэсгийн айл өрхийг дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугаманд холбох, халаалтын 6 дугаар зуухнаас 8 дугаар автобааз, гурилын үйлдвэрийн контор хүртэлх дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийж, ашиглалтад өглөө.

Булган сумын Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урд талд шинээр баригдах “Шинэ хотхон”, 6 дугаар баг “НИК-Петровис” ШТС-ын урд 630 кВа-ийн 2 ширхэг трансформатор бүхий хаалттай 2 дэд станц барьсан. Орхон сумын нэгдсэн халаалтын систем барих ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж, сумын төвийн бүх байгууллагууд холбогдсон.

“Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төслөөр Могод сумын халаалтын зуух, гадна дулааны шугам сүлжээг шинэчлэн сольж, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийг холбосон. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хялганат тосгоны нэгдсэн халаалтын системийг барих ажил хийгдэж байна.



**/Тухайн жил 76,3 хувь/  
/Өссөн дүнгээр 56,3 хувь/**

**Зорилт 1.18.** Орон нутагт мэдээлэл холбооны үндсэн сүлжээг өргөтгөж шинж техник технологи нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Холбоо мэдээллийн сүлжээний чанар хүртээмж дээшилнэ.

Шилэн кабельд холбогдоогүй Могод, Тэшиг, Баян-Агт, Сэлэнгэ, Хангал, Бүрэгхангай зэрэг 6 сумдад 325 км шилэн кабель татаж, ашиглалтад оруулснаар аймгийн бүх сумд шилэн кабелийн сүлжээнд холбогдож, өндөр хурдны интернетэд холбогдох нөхцлийг бүрдүүлсэн.

Хөдөөгийн сумдыг интернетжүүлэх ТН-03/12 төслөөр Баян-Агт, Могод, Тэшиг, Бүрэгхангай, Сэлэнгэ, Хангал сумдын ЗДТГ, эмнэлэг зэрэг байгуулагуудад шилэн кабель татаж, тоног төхөөрөмж суурилуулан интернетэд холбож, 6 сарын хугацаанд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна.

Тэшиг суманд 64/32 багтаамжтай MSAN, Дашинчилэн, Сэлэнгэ суманд 48 багтаамжтай DSAM, Баяннуур суманд 24 багтаамжтай DSAM станц суурилуулан, Хялганат тосгонд MICOM интернетийн үйлчилгээ оруулсан. Эдгээр ажлуудад нийт 87,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Эдгээр ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 151 байгуулага, аж ахуйн нэгж, 449 айл өрх, бүгд 600 интернетийн байнгын хэрэглэгч болоод байна.

**/Тухайн жил 82.5 хувь/  
/Өссөн дүнгээр 75 хувь/**

**Нийгмийн халамж, хамгааллын салбарт:**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөрийн насны иргэнээ ажлын байраар хангана.

**Зорилт 1.19.** “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, нийт 6000-аас доошгүй ажлын байрыг бий болгож, мэргэжилгүй 2000-аас доошгүй иргэдийг сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.

Хүрэх үр дүн: Ажилгүйдлийн түвшин 2012 оныхоос буурсан байна.

“Ажлын байр бий болгох аймгийн хөтөлбөр”-ийг шинээр батлан хэрэгжүүлж иргэдийг томоохон төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг арга хэмжээний үр дүнд улирлын ажлын байр 709, байнгын ажлын байр 938 нийт 1647 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оны мөн үеийхтэй харьцуулахад 458 шинэ ажлын байраар буюу 72,1 хувиар өссөн дүнтэй байна.

Ажилгүйдлийн түвшин 2014 онд 18,6 хувьтай байна.

**/Тухайн жил 95.0 хувь /  
/Өссөн дүнгээр 50,0 хувь/**

**Зорилт 1.20.** “Хөдөлмөрийн бирж” байгуулж, “Хөдөлмөрийн нэг цэгийн үйлчилгээ”-г бий болгоно.

Хүрэхүрдүн:Хөдөлмөр эрхлэлт, ажлын байртай холбоотой мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болно.

Иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор Нэг цонхны ба цахим мэдээллийн самбар, Е-биржийн үйл ажиллагааг сумдад нэвтрүүлснээр Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд идэвхтэй ажил хайгч 762 иргэн, ажил олгогч 429 ажилд зуучлагдсан 731 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд идэвхитэй ажил хайгчаар 119 иргэнийг бүртгэлээ. Мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг 774 иргэнд өгч 4,2 сая төгрөгийг зарцуулан “Ажлын хөтөч”, “Өөрчлөлтийг өөрөөсөө” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж мэргэжлийн чиг баримжаа олголоо. Нэг цонхны үйлчилгээгээр энэ онд нийт 127 хүнд зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллалаа.

**/Тухайн жил 100.0 хувь /  
/Өссөн дүнгээр 50.0 хувь/**

**Зорилт 1.21.** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан элсэгчдийг ажил олгогчийн захиалгаар МСҮТ-д элсүүлж, төгсөгчдийн 70,0 аас доошгүй хувийг ажлын байраар хангана.

Хүрэхүрдүн: МСҮТ-ийн төгсөгчдийн 70,0-аас доошгүй хувийг ажлын байраар хангасан байна.

2014-2015 оны хичээлийн жилд МСҮТ-үүдэд ажил олгогчийн захиалгаар элсэлт авч 18 чиглэлээр 304 мэргэжилтэй ажилтан бэлтгэн төгсгөж төгсөгчдийн 80 гаруй хувийг ажлын байраар хангалаа.

“Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд Булган аймагт үйл ажиллагаа явуулдаг 31 аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар МСҮТ-үүдэд Барилга, үйлдвэр үйлчилгээ, ХАА-н чиглэлээр 10 мэргэжлээр нийт 171 иргэнийг сурган мэргэжилтэй болгосон ба ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах дөрвөлсөн гэрээ хийсний дагуу төгсөгчдийг захиалга өгсөн ажлын байранд нь шууд зуучлан 170 иргэнийг буюу 99 хувийг байнгын ажлын байртай болголоо.

**/Тухайн жил 100 хувь /**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.22.** Нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээр, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Нийгмийн түншлэлийн 3 талт гэрээний төлөвлөгөөний биелэлт 90,0-ээс дээш хувьтай байна. Үйлдвэрлэлийн осол бүүрсан байна.

2013-2014 оны “Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээр”-ийг аймаг, суманд байгуулан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах зорилгоор өмчийн бүх хэлбэрийн 349 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Аймгийн хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт гэрээний биелэлт жилийн эцсийн байдлаар ,, ,, ,, хувьтай хэрэгжлээ.

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

**Зорилт 1.23.** Нийгмийн халамж, даатгалын үйлчилгээг өргөжүүлж, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа хийж, 800-аас доошгүй өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн: Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн нийт өрхөд эзлэх хувь буурна.

2014 онд аймгийн хэмжээнд 338 өрхийн амьжиргааг сайжруулахаар өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран “Хөгжлийн хөтөч” аяныг зарлан байшинжуулах хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зэрэг томоохон төсөл хөтөлбөрт хамруулан ажилласаны үр дүнд 94,7 хувь буюу 283 өрхийн амьжиргаа дээшилсэн дүнтэй байна.

ООТА-ын судалгааны дүнгээр аймгийн хэмжээнд ядуурлын түвшин 20,3 хувьтай байна.

**/Тухайн жил 100 хувь /**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 1.24.** Ахмадаа халамжилж, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангаж, “Хүүхдэд ээлтэй орон нутаг”-ийг хөгжүүлж, жендерийн эрх тэгш байдлыг хангана.

Хүрэхүрдүн: Хүнамынөсөлт 2,0 хувьдхүрнэ

2014 онд “Жендэрийн тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөр”, “Хүүхэд хамгааллыг сайжруулах аймгийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж, Хүүхэд залуучуудын парк, Хүүхдийн Жаргалант зуслангийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан тохижилтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж 2,5 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийлээ. Аймгийн хүн амын өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,9 хувиар өссөн байна.

**/Тухайн жил 93.0 хувь /**

**/Өссөн дүнгээр 54,3 хувь/**

**Төсөв санхүүгийн чиглэлээр:**

Аймгийн төсөв, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.

**Зорилт 1.25.** Татварын бааз суурийг өргөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Төсвийн орлогын төлөвлөгөө биелж, орлого нэмэгдсэн байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн дагуу аймгийн хэмжээнд үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан тогтоох ажлыг зохион байгуулж ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013.01.09-ний өдрийн 04 дүгээр тогтоол батлуулан аймгийн хэмжээнд мөрдөн ажиллаж байна. Татвар ногдох хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн тооллогыг Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу зохион байгуулж, нийт 136,0 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 11193 үл хөдлөх хөрөнгийг тооллогод хамруулсан. Булган аймгийн үндсэн иргэн нь орон нутгийн дугаар бүхий тээврийн хэрэгсэл эзэмших ба гадны дугаар бүхий тээврийн хэрэгслийн дугаарыг солиулах талаар үүрэг болгосон Аймгийн Засаг даргын захирамжийг гарган 639 тээврийн хэрэгслийн дугаарыг орон нутгийн дугаараар солиод байна. Хөтөлбөр хэрэгжиж байгаа энэ хугацаанд татвар төлөгч ажа хуйн нэгж, байгууллага 165 татвар төлөгчөөр буюу 15.2 хувиар, татвар төлөгч иргэдийн тоо 8915 татвар төлөгчөөр буюу 73.4 хувиар нэмэгдээд байна.

"Татварын албаны мэдээллийн систем"-ийн цогц программ хийгдэж байгаа бөгөөд сумдын байцаагч нарыг дээрхи нэгдсэн сүлжээнд холбосоноор графикт тайлан мэдээг цаг хугацаанд нь шалган хүлээн авч, мэдээллийн сангийн үзүүлэлтүүдийг баяжуулж шаардлагатай мэдээллээр ханган ажиллах бололцоотой болно.

**/Тухайн жил 87.5 хувь /  
/Өссөн дүнгээр 43.1 хувь/**

**Зорилт 1.26.** Орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хөгжлийн бодлого, зорилго зорилттой уялдуулан хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилж хэрэгжүүлэх, төсвийн ил тод, тунгалаг байдлыг хангана.

Хүрэх үр дүн: Төсвийн үр ашиг ашиг дээшилж, төсөв ил тод болсон байна.

Аймгийн ОНХ Сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжих төсөл арга хэмжээний саналыг сумдад нээлттэй хэлэлцүүлэн санал авч аймгийн ЗДЗ, ИТХ-д хэлэлцүүлэн батлууллаа. 2014 оны батлагдсан төсөв, хурлын тогтоол, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгдсэн тайлан, 2013 оны төсвийн нэгдсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт зэргийг аймгийн [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) вэб сайт, "Булганы мэдээ" сонин, "Шинэ Булган" мэдээллийн эмхэтгэлд байршуулан иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргаар батлагдсан тухайн жилийн төлөвлөгөө, түүнд үндэслэсэн гүйцэтгэлийн мэдээ тайлан, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар болон хуульд заасан бусад аргаар зохион байгуулагдаж байгаа тендерийн зарыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn), Булган аймгийн цахим хуудас [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) хаягаар нийтлэхийн зэрэгцээ Монголын өдөр тутмын сонин хэвлэлүүдэд тухай бүр нь тогтмол хэвлэн мэдээлж байна. Сангийн сайдын 2013 оны 01 сарын 11-ний өдрийн 01 тоот тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах", 2013 оны 04 сарын 19-ний өдрийн 84 дүгээр тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүнг нийтлэх" журмын дагуу цахим тендерийн өрөөг бүрэн камержуулж тоноглон худалдан авах ажиллагааны тухайн жилд батлагдсан төсөл арга хэмжээнээс 2 тендерийг цахим худалдан авах ажиллагааны журмаар амжилттай зохион байгуулсан.

**/Тухайн жил 96.0 хувь/  
/Өссөн дүнгээр 57.0 хувь/**

**Зорилт 1.27.** Нягтлан бодох бүртгэл, аудит, дотоод хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарлагын хэмнэлтэнд эерэг нөлөө үзүүлэх, бүх шатны удирдлагад санхүү, эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

Хүрэх үр дүн: Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн 72,3 хувь буюу 602 байгууллагаас хүлээн авч "И-Баланс" программд нэгтгэн илгээсэн. "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 тоот тогтоол, "Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай" Сангийн сайдын 2014 оны 122

тоот тушаалыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт гаргаж сум, төсвийн байгууллагын удирдлагад хүргүүлэн хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. 2013 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлаар бүх сумдад ажиллаж Төсвийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг шалган, газар дээр нь зөвлөгөө өгч ажиллаж үр дүнг тооцон Сангийн яаманд хууль, журмын өөрчлөлт бусад саналыг хүргүүлэн ажиллалаа.

**/Тухайн жил 94.0 хувь/  
/Өссөн дүнгээр 42.0 хувь/**

**Зорилт 1.28.** Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангана.

Хүрэх үр дүн: Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангаж ажилласан байна.

Тус аймагт “Монгол даатгал”, “Номин” даатгал, “Практикал” даатгал, “Миг” даатгал, “Ард” даатгал, “Бодь” даатгал, “Тэнгэр” даатгал, “ХААН” даатгал, “Соёмбо” даатгалын салбарууд нь гэнэтийн осол, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал зэрэг төрлүүдээр даатгалын үйлчилгээг үзүүлж байна. Албан журмын даатгагчдын холбооны орон нутаг хариуцсан менежерийг томилуулж ажлыг жигдрүүлснээр өнөөдрийн байдлаар 2 орон тоотойгоор, 1 тусгай зориулалтын дуудлагын машинтай үйл ажиллагаа явуулж байна. Албан журмын даатгалын 13 тохиолдолд 5,5 сая төгрөгийн нөхөн олговор олголоо. Булган брокерын пүүст 13557 данс эзэмшигч байгаа бөгөөд үүний 1089 нь “Тавантолгой” ХК-ны хувьцаа эзэмшигч байна. Энэ онд 50 ХК-ны 120 хувьцааг борлууллаа. Хувьцааны ногдол ашгийн мэдээлэл тархалтын судалгаа, үнэт цаасны арилжааны мэдээлэл хангалтгүй байна. “Хас” банкны Булган салбартай хамтран Хутаг-Өндөр суманд “Ханнамнан хөгжил” ХЗХ, Гурванбулаг суманд “Хөгнөхан хөгжил” ХЗХ, Дашинчилэн суманд “Цогтын хишиг” ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа ба гишүүдийн тоо өсч зээлийн багцын чанар сайжран үйл ажиллагаа тогтмолжоод байна. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дүнг ХЗХ-д хүргүүлж, үр дүнд дүгнэлт хийж ажиллах чиглэл өгч ажиллалаа.

**/Тухайн жил 85.0 хувь/  
/Өссөн дүнгээр 42.5 хувь/**

**Зорилт 1.29.** Статистикийн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг бэхжүүлж, албан ёсны статистикийн мэдээ мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, үнэн бодит шуурхай, ил тод байдлыг хангана.

Хүрэх үр дүн: Статистикийн хараат бус, бие даасан байдал хангагдаж, мэдээллийн түгээлт, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

“Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” ийг аймгийн ИТХТэргүүлэгчдээр хэлэлцүүлэн 2013 оны 06-р сарын 77 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүний чанар, загвар, өнгө үзэмжийг сайжруулан, захиргааны мэдээллийн хамрагдалтыг нэмэгдүүлж 47 төрлийн мэдээлэлийг цуглуулан үр дүнг боловсруулан тархаан ажиллаж байна. Мөн хөтөлбөрийг нийт ажилтнуудад хариуцуулан хэрэгжилтийг улирал тутам тооцон ажиллаж байна.

Хүн ам өрхийн мэдээллийн санг улсын бүртгэлд суурилсан онлайн хувилбарт шилжүүлэх ажил шат дараатай хийгдэж байна. 6 сарын 13-26 ны хооронд төлөвлөгөөний дагуу 76 багийн Засаг дарга, 17 Төрийн сангийн төлөөлөгч нарт “Хүн ам өрхийн мэдээллийн сан”-г онлайн орчинд ажиллуулах сургалтыг бүсчилэн зохион байгуулсан. Сургалтын ирц 100 хувь оролцож, сургалтын чанар хангалттай түвшинд явагдсан. Мөн багийн Засаг дарга нарыг дадлагажуулах зорилгоор 9-р сар хүртэл туршилтын программыг ажиллуулж байгаад 10-р сараас эхлэн ХАӨМС-ын программыг албан ёсоор ажиллуулж эхлээд байна. ХАӨМСангийн онлайн программд 2014 оны 03 дугаар улирлын байдлаар манай аймгийн 54522 мэдээлэл алдаагүй орсон бөгөөд УБЕГ-ын мэдээллийн сантай овог, нэр, регистр зөрсөн 4153 хүний мэдээллийг засварлах ажлыг 10 сарын 12-ноос 10 сарын 29 хугацаанд

зохион байгуулж 11 сарын 03-ны байдлаар ХАӨМСанд 59574 хүний мэдээллийг алдаагүй үнэн зөв оруулаад байна.

Цахим хэрэглээг хэвшүүлэх, мэдээллийн түргэн шуурхай байдлыг хангахад анхаарч хэрэглэгчийн цахим хаягийг бүртгэн, аймгийн нийгэм эдийн засгийн мэдээллийг цахимаар давхардсан тоогоор 772 хэрэглэгчидэд тархаан ажиллаж байна. Мөн 1212.mn, [bulgan@nso.mn](mailto:bulgan@nso.mn) хуудасыг сурталчилах “Булганы мэдээ” сонинд 16 сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдээр “Статистикийн толинд” танилцуулгыг бэлтгэн, “Шинэ Булган” сонинд үнийн мэдээ болон цаг үеийн мэдээлэл бэлтгэн хэрэглэгчдэд тархаан ажиллаж байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 48.3 хувь/**

## **ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ БУЛГАНЧУУД**

Нийгмийн эрүүл мэнд давамгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 2.30.** Нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогооны төв болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, телемедицины Үндэсний сүлжээнд холбоно.

Хүрэхүрдүн: Нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралтыг 20,0-оос доошгүй хувиар бууруулсан байна.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэн Нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогоо, эмчилгээний төв болгох бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, 479.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийлээ. Нэгдсэн эмнэлэгт хийгдэх засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр стандартын хангалт өнгөрсөн оноос 5.2 хувиар нэмэгдэж 90.6 хувьд хүрч, аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд чанарын ахиц гарлаа. Телемедицины үндэсний сүлжээнд холбоход шаардлагатай 18.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган, 86 удаагийн хуралд давхардсан тоогоор 1851 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа.

**/Тухайн жил 98.0 хувь/  
/Өссөн дүнгээр 59.5 хувь/**

**Зорилт 2.31.** Сум, өрхийн ЭМТ-ийг боловсон хүчин, оношлогоо-эмчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хийнэ.

Хүрэхүрдүн: СДЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн стандарт хангалтыг 93.0 хувьд хүргэнэ.

“Сумын эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги /2014-2016/”, “аймгийн Нэгдсэн эмнэлгийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги /2014-2016/” бодлогын томоохон баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж, сум, өрхийн Эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийг 17 нэр төрлийн нийт 65.6 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуураар, 38.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр, аймгийн Нэгдсэн эмнэлгийг 45.0 сая төгрөгийн задлан шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангалаа. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалт 96 хувьтай байна.

**/Тухайн жил 92.0 хувь/  
/Өссөн дүнгээр 46 хувь/**

**Зорилт 2.32.** Эх, нялхасын эндэгдэл, сүрьеэ, бруцеллёз, халдварт шар, БЗДХӨ-ийг тууштай бууруулж, хувийн эрүүл мэндийн байгууллагын өрсөлдөөнийг бий болгож, үйл ажиллагааг дэмжин бүх шатанд эмчилгээ оношлогоог чанаржуулна.

Хүрэх үр дүн: Эхийн эндэгдэлгүй ажиллаж, нялхасын эндэгдэл, сүрьеэ, бруцеллёз, халдварт шар, БЗДХӨ-ийг улсын дундажаас бууруулна.

“Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжихэд салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь” жилийн ажлыг эрчимжүүлэн 341 жирэмсэн эмэгтэйчүүд, 350 гаруй нярайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн, хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг, “Охид” арга хэмжээнд 3976 охид, эмэгтэйчүүдийг хамрууллаа.

Эхний 10 сарын байдлаар нийт 852 эх төрж, эхийн эндэгдэл гараагүй, перинаталь эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 9.3 байгаа нь улсын дунджаас 5,1 промилээр доогуур байна.

Аймгийн хэмжээнд халдварт өвчний 329 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны түвшнээс 26,6 промилээр буурч, үүний дотроос халдварт шар өвчний тохиолдол 6.0 гарч 10000 хүн амд 5.5 промилээр буурлаа.

**/Тухайн жил 85 хувь/  
/Өссөн дүнгээр 45 хувь/**

### **2.33. Донорын хөдөлгөөн өрнүүлж, цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээг бий болгоно./2013-2016/**

Хүрэх үр дүн: Цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээ төлөвшиж, хүн амын 1,0 хувь нь донор болсон байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Цусны салбар банкны цус, цусан бүтээгдэхүүнийг хадгалах, чанар аюулгүй байдал, нөөцийг бүрдүүлэх, доноруудад ээлтэй орчин бий болгох зорилгоор орон нутгийн хөгжлийн сангаас 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж, “Хүндэт Донор шалгаруулж, шагнах аймгийн журам”, “Донорын эгнээг өргөжүүлэгч Хүндэт байгууллага” шалгаруулах журмыг боловсрууллаа.

Цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах аюулгүй байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг хэрэгжилтийг эрчимжүүлэн бүсчилэн сургалт зохион байгуулж сумдын 55 эмч, мэргэжилтнийг хамрууллаа.

**/Тухайн жил 95 хувь/  
/Өссөн дүнгээр 48,75 хувь/**

### **2.34. Эмийн чанар аюулгүй байдлыг хангаж, иргэдэд чанарын өндөр шаардлага хангасан эмээр үйлчилнэ.**

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд аюулгүй, чанарын баталгаатай, эм биобэлдмэл, уламжлалт эмээр хангагдаж, эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэг дээшилнэ.

Аймгийн хэмжээнд зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 11 сарын байдлаар 89.0 хувьд, эмийн эргэлтийн сангуудын стандартын хангалт 89.5 хувьд хүрлээ. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2014 онд хөнгөлөлттэй эмэнд нийт 174.4 сая төгрөгийг төсөвлөснөөс эхний 10 сарын байдлаар санхүүжилтийн гүйцэтгэл 135,4 сая төгрөг буюу 77.6 хувьтай болж өнгөрсөн оны мөн үеэс 12.6 хувиар нэмэгдлээ.

**/Тухайн жил 80 хувь/  
/Өссөн дүнгээр 41,25 хувь/**

### **2.35. Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, боловсролыг дээшлүүлнэ.**

Хүрэх үр дүн: Эмч, мэргэжилтнүүдийн 30-аас доошгүй хувь мэргэжлийн зэрэгтэй болно.

Аймгийн хэмжээнд сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалт 96 хувьд хүрч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөгжлийн төлөвлөгөөг 5 жилээр боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2014 онд төрийн санхүүжилтээр 17 төрлийн мэргэжлээр 53 эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх болон, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, 33 эмнэлгийн мэргэжилтнийг давтан мэргэжил дээшлүүлэх сургалтанд, Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан 33 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 315 эмч, мэргэжилтэнг тус тус хамрууллаа.

**/Тухайн жил 96.7 хувь/  
/өссөн дүн 49.2 хувь/**

### **2.36. Эрүүл мэндийн салбарт шаардлагатай шинэ барилгыг барьж, их засвар хийх ажлыг үе шаттайгаар хийнэ.**

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах орчин стандартын түвшинд хүрсэн байна

2014 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд 2.144.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 ортой төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийг шинээр барьж ашиглалтанд орууллаа. Хутаг-Өндөр сумын сум дундын эмнэлгийн 879.4 сая төгрөгийн төсөвт

өртөг бүхий барилгын ажил 95 хувьтай явагдаж байна. Булган сумын “Цоожэд” өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг 85.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барьлаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сантехникийн 100.0 сая төгрөгийн их засвар, Рашаант сумын эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн 112.0 сая төгрөгийн их засварыг тус тус гүйцэтгэлээ.

**/Тухайн жил 78.0 хувь/  
/өссөн дүн 48.0 хувь/**

**2.37. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэн, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэн, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх**

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог 45 болгон нэмэгдүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, халдварт болон халдварт бус өвчинтэй тэмцэх стратеги, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх стратегийг хэрэгжүүлэн, аймгийн Засаг даргын захирамжаар “Нэрэмжит сар”-ын аяныг зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжигч аж ахуйн нэгж, албан байгууллага, өрх, гэр бүлийг шалгаруулах болзолт уралдаануудыг зарлан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын аймгийн болзлыг хангасан 24 байгууллага, улсын болзлыг хангасан 1 байгууллага ажиллаж байна. Хүн амын дунд заавал эзэмшвэл зохих 21 дадал “Эрүүл мэндийн довтолгоо” үйл ажиллагааг хэрэгжүүлэн 70 гаруй удаагийн сургалтанд 45 байгууллагын 6372 албан хаагч, иргэдийг, эрүүл мэндийн боловсрол олгох явуулын сургалтыг 16 суманд зохион байгуулж 17549 иргэнийг хамрууллаа.

**/Тухайн жил 91.7 хувь/  
/өссөн дүн 44.9 хувь/**

**2.38. Цана, тэшүүр, гарбөмбөг, буудлага, жуд-до, үндэсний спортыг түлхүү хөгжүүлж өсвөр үеийн шигшээ баг хичээллүүлэн, шинэ спортыг хөгжүүлнэ.**

Хүрэхүрдүн: Тив, дэлхий, олон улсад амжилт гаргах тамирчид төрөн гарах алдартай тамирчдын хойч үеийг бэлтгэх, аймагт хөгжсөн онцлог спортын төрлүүдийг олон нийтийн хүртээл болгох

Уран уурагч, бугуйлч, эмнэг сургагчдын УАШТэмцээнийг спортын 3 төрлөөр зохион байгуулан 18 аймгийн 100 гаруй тамирчид оролцлоо. “Морьтон монгол” гиннессийн дээд амжилтанд бүртгүүлэх 11125 морьтон монголчуудын их жагсаал, 4249 морьдын уралдаанд Булган аймгаас 697 морь жагсаж 564 морь уралдуулж оролцоо.

Үндэсний спортын их наадамд аймгаас төлөөлөн оролцох тамирчдын бэлтгэлийг хангуулж оролцуулснаар уран уургагч бугуйлчийн төрөлд Алтан медаль, Үндэсний бөхийн сумын цолтонгууд тэргүүн байр, аймгийн цолтонгууд 2-р байр, Улсын цолтонгууд 3-р байр тус тус эзлэн аймгийн дүнгээр бөхчүүд улсад тэргүүлсэн амжилтыг үзүүллээ.

Ахмад волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн, Монгол улсын гавьяат дасгалжуулагч Ш.Эрдэнэ-Очирын нэрэмжит жу-до бөхийн Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж нийт 12.5 сая төгрөгийг аймгийн төсвөөс зарцууллаа.

Улс, олон улс, тивийн аварга, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд тус аймгийн тамирчид алтан медаль-75, мөнгөн медаль-49, хүрэл медаль-52, олон улсын тэмцээнээс алтан медаль-2, мөнгөн медаль-2, хүрэл медаль-1, тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 хүрэл, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 2-г хүртэж Улс, олон улс, тив, дэлхийн болон Үндэсний спортын наадамд амжилт гаргасан тамирчдад 18,0 сая төгрөгийг олгоод байна

Самбо бөхийн дэлхийн болон Ази тивийн аварга, ОУ-ын хэмжээний мастер Б.Ариун-Эрдэнийн нэрэмжит самбо бөхийн олон улсын хотуудын нээлттэй тэмцээн зохион байгуулан ОХУ-ын Буриад, ӨМӨЗО-ны Хөх хот, Шилийн гол аймаг болон 8 аймаг Улаанбаатар хотын 6 дүүргийн 375 тамирчид оролцлоо.

Монгол улсын гавьяат дасгалжуулагч Ш.Эрдэнэ-Очирын нэрэмжит жу-до бөхийн Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан 6 аймгийн 300 шахам тамирчид оролцлоо.

**/Тухайн жил 96.0 хувь/  
/Өссөн дүнгээр 46,5 хувь/**

### **2.39.Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ**

Хүрэх үр дүн: Шатрын спортын амжилт ахисан байна.

Шатар аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бүх сумдад шатрын клуб, танхимууд хичээллэж 2014 оны байдлаар шатрын спортоор сонирхон хичээллэх хүүхдийн тоо 7000-д хүрсэн нь нийт суралцагчдын 73 хувийг эзлэж байна.

Өсвөр үе, Насанд хүрэгчид, Ахмад, багийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, бусад нэрэмжит тэмцээнүүдийг 26-г зохион байгуулж 6800 тамирчин давхардсан тоогоор оролцсон байна.

Шатрын Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдэд 71 тамирчид оролцож Алтан медаль 3, Мөнгөн медаль 4, хүрэл медаль 1 амжилт үзүүлж Булган сумын 1-р 12 жилийн 76 ангийн сурагч Наранбаатарын Номин-Эрдэнэ Тайвань улсын Тайчун хотод болсон Ази тивийн сурагчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцож хүрэл медаль Цомын эзэн болж, Булган аймгаас төрөн гарсан 3 дахь удаагийн Фидемастер боллоо.

500 хүүхдийн шатрын тэмцээнийг 5 насны ангилалтайгаар зохион байгуулж, Булган сумын 1-р сургууль тэргүүн байр, ЭӨЦС 2-р байр, Хишиг-Өндөр сум 3-р байр эзэллээ.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 49,3 хувь/**

**2.40.Сум бүр /ЕБС/-т ногоон байгууламж бүхий чийрэгжүүлэлт, биеийн тамир, спортын болон хөл бөмбөг /мөсөн гулгуур/-ийн талбай, гүйлт, дугуйн зам байгуулна.**

Хүрэх үр дүн: Сумдын хүүхэд залуучууд, ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, дасгал хөдөлгөөн хийх зориулалтын талбайтай болж иргэд өөрсдийн санаачлагаар идэвхитэй дасгал хөдөлгөөнийг хийж хэвшинэ.

Хутаг-Өндөр, Могод, Бүрэгхангай, Орхон сумдад алхалт, гүйлтийн талбай, ногоон байгууламж бүхий хүрээлэнг 100-120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж байгуулсан ба Хишиг-Өндөр, Булган зэрэг сумдуудад дээрхи ажлууд эхлээд байна. Хөтөлбөр хэрэгжиж байх хугацаанд бүх сумдад чийрэгжүүлэлтийн кабинет, гадаа задгай биеийн тамир чийрэгжүүлэлтийн талбай байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна хүүхдийн тоглоомын талбайг сумд болгон байгуулсан байна.

**/Тухайн жил 85.0 хувь/  
/Өссөн дүнгээр 43,7 хувь/**

**2.41.Усан бассейн байгуулж, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлж байгууллага, аж ахуйн нэгжүүд, “Чийрэгжүүлэх фитнес төв”-тэй болох, спортын холбоод, хамтлагуудын үйл ажиллагааг дэмжих, амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулна.**

Хүрэх үр дүн: 16-аас дээш насны хүн амын 60.0 хувь нь нийтийн биеийн тамираар хичээллэдэг болно.

Нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэхээр аймгийн хэмжээнд Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажилчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндэд нь анхааран амралтын өрөө, ширээний теннис, чийрэгжүүлэлтийн танхим зэрэг 18, аймгийн хэмжээнд нийт 50 гаруй чийрэгжүүлэлтийн танхим үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор Бие бялдар хөгжил чийрэгжилтийн сорил судалгааны ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 3-64 насны 51833 хүнээс 15890 хүний мэдээллийг улсын цахим санд бүртгэснээр нийт хүн амын 31% -ийг бүртгэснээр улсад 3-р байр эзэлж Монгол улсын Ерөнхийлөгчийн өргөмжлөлийг хүртлээ. Амжилт гаргасан тамирчдыг урамшуулах ажлын хүрээнд тамирчдад мөнгөн урамшуулал олгох асуудлыг ИТХурлын 49 тогтоолоор



батлуулан хэрэгжүүлж 2013-2014 онд нийт 18,0 сая төгрөгийг амжилт гаргасан тамирчдад олгоод байна.

**/Тухайн жил 96,6 хувь/  
/Өссөн дүнгээр 59,5 хувь/**

### **ГУРАВ. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ БУЛГАНЧУУД**

**Боловсрол, шинжлэх ухаан:**

**3.42. Ерөнхий боловсролын сургалтад олон улсын стандартыг хэрэгжүүлж, хүүхэд, сурагч, багш нэг бүрийг хөгжүүлж, СӨБ, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.**

Хүрэх үр дүн: Хамран сургалтыг СӨБ-д 81.5, багад 92.0, суурь боловсролд 88.0 хувьд, Ерөнхий шалгалтын дундаж оноо 500-д хүрч, насанд хүрээгүй хүүхдийн үйлдэх гэмт хэрэг зөрчил буурсан байна.

2014 онд СӨБ-ын хамран сургалт 84.2 хувь буюу 1,9 хувиар, бага боловсролын хамран сургалт 88.7 буюу 1,6 хувь, суурь боловсролын хамран сургалт 84,5 хувь буюу 0,5 хувиар тус өслөө. Элсэлтийн Ерөнхий шалгалтын дундаж оноо 499.4 хувьд хүрч өмнөх оныхоос 8,3 хувиар өслөө.

2013-2014 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургууль, 25 цэцэрлэгт зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Гадаад хэлний сургалтыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлээ. “Хүүхэд нэг бүрийн хөгжилд бидний оролцоо аян”-ыг зохион байгуулж, эцэг, эх, иргэд олон нийт, сургууль, цэцэрлэгийн болон эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийг өргөнөөр хамрууллаа.

Аймгийн Төрөлжсөн олимпиадыг анх удаа төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулж, 14 хичээлийн 46 төрлөөр зохион байгуулж 800 гаруй багш, суралцагчийг хамрууллаа. 2013-2014 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын бүх сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

“Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн хүрээнд “Шилдэг заах аргын нэгдэл”, “Бүтээлч багш” уралдаан зарлан тэргүүн байранд Булган сумын 1-р сургууль, ЭӨЦС, Хутаг-Өндөр сумын сургуулийн бага ангийн заах аргын нэгдлүүдэд компьютер, техник хэрэгсэл, бүтээлч багшаар шалгарсан 3 багшид болон ангид нь тус бүр 1 сая төгрөгийн нийт 7 сая төгрөгийн шагнал олголоо

“Авьяс” хөтөлбөрийг хэрэгжүүлж сургууль бүр өөр өөрийн онцлогтой олон төрлийн ажлыг зохион байгуулан зарим ажлыг дэмжиж ЕБС-ууд нийт 57.687.600 төгрөг зарцуулсан байна.

“Авьяс” хөтөлбөрийн үйл ажиллагааны тайланг бүтээлийн болон урлагийн гэсэн 2 төрлөөр суралцагчдын сурсан, мэдсэн, бүтээсэн бүтээлүүдийг эцэг эх, олон нийтэд нээлттэй сурталчилах ажлыг зохион байгууллаа.

Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан “Залуу зохион бүтээгч-2014” улсын уралдаанд Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн сурагч Р.Авирмэд ахлагчтай баг, хамт олны бүтээлээрээ улсад 2 дугаар байр, Орхон сумын сургуулийн сурагч Ц.Баасанцогт ахлагчтай баг, хамт олны бүтээл Улсын уралдааны шилдэг 16 бүтээлд тус тус шалгарлаа.

**/Тухайн жил 90.0 хувь/  
/Өссөн дүнгээр 49,2 хувь/**

**3.43. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгэм-хамт олонд түшиглэн сургуулийн өмнөх болон бага, суурь боловсрол эзэмшүүлнэ.**

Хүрэх үр дүн: Цэцэрлэгт сурч байгаа ХБХ-ийн тоо 10.0 хувиар, сургуульд сурч байгаа ХБХ-ийн тоо 5.0 хувиар нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин бүрдсэн байна.

Цэцэрлэгт хамрагдах боломжтой Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 80 гаруй хувь нь цэцэрлэгт хамрагдаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаж буй ХБХ-ийн тоо 1 хувиар өсч, сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 6 хувиар буурсан байна. 2014 онд сургууль, цэцэрлэг нэг бүрээс 1 хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй сургалтанд нийт 46 хүнийг хамруулж сургагч багшаар бэлтгэлээ. 2014-2015 оны хичээлийн жилд ЕБС-д 194, СӨБ-д 49 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**3.44. “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллага, эцэг эхийн хяналтыг тогтмолжуулж, эрсдлээс урьдчилан сэргийлнэ.**

Хүрэх үр дүн: “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжиж, хүнсний аюулгүй байдлын эрсдэл гараагүй байх

2013 онд Ерөнхий боловсролын 19 сургуульд “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлж 388.1 сая төгрөгийг зарцууллаа. Үдийн цайг сургуулийн гал тогоогоор 17 сургууль, 2 сургууль аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж 5 хоногийн 3-5 өдөрт нь халуун хоол өгч хэвшлээ. 2014 онд “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж 4406 хүүхэд хамрагдаж 394.7 сая төгрөг зарцуулсан байна

“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллага, эцэг эхийн хяналтыг тогтмолжуулж, ажилласнаар, хүнсний аюулгүй байдлын эрсдэл гараагүй байна.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 45,2 хувь/**

**3.45. Сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчны бие засах газар, ариун цэврийн өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөн өрнүүлнэ.**

Хүрэх үр дүн: Нэг угаалтуур, нэг суултуурт ноогдох хүүхдийн тоо 2012 оны үзүүлэлтээс 15-аар буурсан байна.

Цэцэрлэгийн суултуур 78-аар нэмэгдлээ. Эрүүл мэндийн олимпиадыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, дүгнэлээ.

2014 онд Могод, Бүрэгхангай сумд нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системтэй болсноор сургууль цэцэрлэгүүд нь дотроо ариун цэврийн өрөөтэй болох боломж бүрдлээ.

Эрүүл мэндийн газартай хамтран СӨБ, ЕБС-д эрүүл мэндийн хичээл заадаг багш нарт зориулсан чадавхижуулах сургалт зохион байгууллаа. ЕБС-ын сурагчдын дунд “Эрүүл мэндийн зохион бичлэг”-ийн уралдааныг зохион байгуулж дүгнэлээ. 2014 онд Байгал орчныг дэмжих сангийн хөрөнгөөр Баяннуур, Хишиг-Өндөр сумын сургуулийн худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг хийлээ. Хутаг-Өндөр сумын сургууль гүний худагтай болсон.

Могод, Бүрэгхангай сумд нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системтэй болсноор усны хангамжийн асуудал шийдэгдлээ

**/Тухайн жил 93.3 хувь/  
/Өссөн дүнгээр 45,8 хувь/**

**3.46. Сум бүр “Гэгээрэл төв”-ийг ажиллуулан албан бус боловсролыг насан туршийн боловсролын хэлбэрт шилжүүлнэ.**

Хүрэх үр дүн: Бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд 160, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 1500, амьдрах ухааны сургалтанд 6000 хүн суралцсан байна.

Бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд нийт 641 хүн хамрагдаж, Бага боловсролд 121, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 520 хүн суралцлаа.

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамрагдах суралцагчдын тоог шинэчлэн гаргаж 2013-2014 оны хичээлийн жилд насан туршийн боловсролын сургалтанд 343 хүн суралцснаас 73 иргэн суурь боловсролын гэрчилгээ, 82 иргэн бүрэн дунд боловсролын үнэмлэх авлаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**3.47. “Боловсролын байгууллагын менежментийн мэдээллийн систем”-ийг байгуулан сургууль, цэцэрлэгийг интернэтэд бүрэн холбож, мэдээллийн технологийг сургалтанд ашиглаж, боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх**

Хүрэх үр дүн: Цэцэрлэгийн ор 650, дотуур байрны ор 225, хичээлийн байрны суудал 1220-иор нэмэгдэж, бүх сургууль, дотуур байр интернэтэд холбогдсон байна.

Булган суманд 640 суудалтай хичээлийн байр, 150 суудалтай цэцэрлэгийн барилга баригдаж байна, Булган сумын 1-р сургуулийн 640 суудалтай хичээлийн байр, Сэлэнгэ, Бүрэгхангай, Булган сумын 3-р цэцэрлэгийн өргөтгөл, Рашаант, Дашинчилэн сумын дотуур байрны барилгын зураг төсвийг хийлгэлээ.

“Мэдээлэл харилцааны чадамжийг дээшлүүлэх үндэсний төв”-тэй хамтран бүх сургууль, цэцэрлэгийг цахим хуудастай болголоо.

“Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний систем” нэвтрүүлэх сургалтад сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг хамрууллаа. 2014 онд Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар хийх, тоног төхөөрөмж авах ажилд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 192,6 сая, БШУ-ны Сайдын багцаас 723,2 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,2 тэр бум, нийт 8 арга хэмжээнд 2,115,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийлээ.

**/Тухайн жил 94,2 хувь/  
/Өссөн дүнгээр 46,4 хувь/**

**3.48. Сургуулийн захиргаа, сургууль, цэцэрлэгийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, дүрэм, журам зөвлөмжийг хэрэгжүүлнэ.**

Хүрэх үр дүн: Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн зарцуулалтанд олон нийтийн тавих хяналт сайжирч, эцэг эх, сургуулийн хамтын ажиллагаа сайжирна.

Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сангийн зарцуулалтанд эцэг эх, иргэдийн хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар тус аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ажиллах чиглэл, зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм, сургууль, цэцэрлэгийн удирдлагыг дүгнэх аргачлал, зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.

“Хүүхэд нэг бүрийн хөгжилд” бидний оролцоо сэдэвт аян зарлаж, уг аяны хүрээнд бүх ЕБС, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж ажиллуулаа. Сургуулийн захиргаа, сургууль, цэцэрлэгийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн хамтран ажиллах зөвлөмжийг албан бичгээр сумдад хүргүүлэн ажиллаж байна.

**/Тухайн жил 85.0 хувь/  
/Өссөн дүнгээр 40 хувь/**

**3.49. Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулж, халуун устай болгоно.**

Хүрэх үр дүн: Бүх дотуур байр халуун устай болж, хичээл давтах танхим, номын сантай болсон байна.

Ерөнхий боловсролын Сургуулийн дотуур байрны 27 хувь нь халуун устай, бүх дотуур байр хичээл давтах танхимтай, номын сантай, Сэлэнгэ, Рашаант сумын дотуур байр “Цахим” номын сантай боллоо. Бугат сумын сургуулийн халуун усны барилгын зураг төсвийг хийлгэснээр, бүх дотуур байр нэг загварын халуун усны зураг төсөвтэй боллоо.

**/Тухайн жил 0 хувь/  
/Өссөн дүнгээр 43.3 хувь/**

**3.50. Биеийн тамир, спорт заалыг тоног төхөөрөмжөөр хангаж, биеийн тамирын гаднах талбайг тохижуулна.**

Хүрэх үр дүн: Биеийн тамир, спортын нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаж, гаднах талбайг шинэчлэн сайжруулсан байна.

Ерөнхий боловсролын 5 сургууль спортын тоног төхөөрөмжөөр хангагдаж, 4 сургууль гадна биеийн тамирын талбайгаа тохижууллаа.

Бугат, Сайхан сумын сургуулиуд дотоод нөөц бололцоонд тулгуурлан биеийн тамирын гадна талбайг тохижууллаа.

Хутаг-Өндөр, Баян-Агт, Бүрэгхангай, Орхон сумд гадна биеийн тамирын талбайгаа шинэчлэн тохижуулж ашиглалтад орууллаа. Хутаг-Өндөр сумын сургууль сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр гадна талбайдаа хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбайг шинээр хийж, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулан, гэрэлтүүлэгтэй болгосноос гадна “Жигүүр гранд” компанитай хамтран ажиллаж спорт зааландаа иж бүрэн засвар, шинэчлэлийн ажил хийлээ.

2014 онд Могод сумын сургууль гадна биеийн тамирын талбайгаа шинээр байгууллаа.

**/Тухайн жил 85.0 хувь/  
/Өссөн дүнгээр 37,5 хувь/**

**3.51. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Газар хөдлөлтийн станцыг геофизикийн цогц орчин үеийн багаж техник хэрэгслээр хангана.**

Хүрэх үр дүн: Мэдээлэл бүрдүүлэлт, дамжуулалтыг 95,0-д хүргэнэ.

Газар хөдлөлтийн станцыг геофизикийн цогц орчин үеийн багаж техник хэрэгслээр хангаж, мэдээлэл бүрдүүлэлт дамжуулалт 95,0 хувьд хүрлээ. 2014 онд Хүчтэй газар хөдлөлтийн үед “Амжиж анхааруулах систем” Дашинчилэнд суманд 1 станц, Могод суманд 3 станц, нийт 4 станц ашиглалтад орлоо.

2014 онд Хүчтэй газар хөдлөлтөөс “Амжиж анхааруулах систем /ААС/ Могод суманд 3 станц, Дашинчилэн суманд 1 станц нийт 4 станц байгуулан ашиглалтанд орж Одон орон геофизик судалгааны төв хүлээн авлаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**3.52. Соёл урлагийг 2012-2021 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.**

Хүрэх үр дүн: Үндэсний өв соёлоо дээдлэн үламжилж түүнд тулгуурласан соёлын аялал жуулчлал, бүтээлч аж үйлдвэрийг хөгжүүлж соёл урлагийн салбарыг аймгийн хөгжлийн үндсэн үзүүлэлт болгож хөгжүүлнэ.

Соёлын салбарын ажилтан уран бүтээлчдийг чадавхижуулах сургалтыг 9 удаа зохион байгуулж 302 хүн хамруулснаар урьд онтой харьцуулбал сургалтын тоо 2 дахин нэмэгдэж соёлын байгууллагын ажиллагсдын дундах мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 82 хувьд хүрсэн байна. 2014 оны оны 10 сарыг “Соёлын сар” болгон зарлаж соёлын салбарын уран бүтээлч, ажилчидтай хамтран соёл, урлагийг иргэдэд сурталчилах зорилгоор “Соёлын гудамж” фестивалыг зохион байгууллаа.

“Морин хуур” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 59.0 сая төгрөгийг төлөвлөж 23 сургагч багшийг 2 удаагийн сургалтанд хамруулж өнөөгийн байдлаар 467 хүүхэд, 201 насанд хүрэгчдийг морин хуурын сургалтанд хамруулж байна.

Үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээнд 333 морин хуурчдыг аймгийн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд оролцуулж, Монгол улсын анхны алдарт гавьяат хөгжимчин Д.Түдэв хуурчийн нэрэмжит “Булганхангайн эгшиглэн” өсвөрийн морин хуурчдын анхдугаар уралдааныг зохион байгуулж 15 сумын 171 хүүхэд оролцлоо.

**/Тухайн жил 97,2 хувь/  
/Өссөн дүнгээр 45,4 хувь/**

**3.53. Соёлын төв, номын сангуудыг интернетэд холбож “Мэдээллийн төв” болгоно.**

Хүрэх үр дүн: Сумын номын сангийн байнгын үншигчидыг 20.0 хувьд хүргэх, нүүдлийн сангаар үйлчлүүлэгчдийг 30.0 хувьд хүргэх

Аймгийн хэмжээнд нийт соёлын салбарын байгууллагын 95.0 хувь интернэтэд холбогдож, Могод, Хангал, Хялганат, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Гурванбулаг сумын соёлын төв номын сангуудыг интернетэд холбон мэдээллийн төв болгон ажиллуулж байна.

Монгол улсын Ерөнхийлөгч зарлигийг хэрэгжүүлж “Номын баяр”, оны шилдэг “Оюунлаг хүүхэд” шалгаруулах уралдаант, цэнгээнт, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг зохион байгуулж ном унших хөдөлгөөн өрнүүлэн 24803 хүн номын сангаар үйлчлүүлж, Нүүдлийн номын сангийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 6887 хүнд 3342 номоор үйлчилүүлсэн байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 9,1 хувь/**

**3.54. Соёлын байгууллагуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр хангах, материаллаг баазыг сайжруулна.**

Хүрэх үр дүн: Соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.

Мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төвүүдийг техник хэрэгслэлээр хангах, материаллаг баазыг сайжруулахаар нийт 129.3 сая, аймгийн ХЖТ-т 278 сая, Рашаант сумын соёлын төвийг 150 сая төгрөгний их засварын ажлыг хийж гүйцэтгүүлээ

Бүрэгхангай сумын соёлын төвийн барилгын их засварыг 190,0 сая төгрөг, Рашаант сумын соёлын төвийн барилгын засварт 150,0 сая төгрөг, Дашинчилэн сумын соёлын төвийн засварт 10 сая төгрөгийг шийдүүлж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж засварын ажлыг хийж дуусгалаа.

**/Тухайн жил 95 хувь/  
/Өссөн дүнгээр 55 хувь/**

### **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ БУЛГАНЧУУД**

**Байгаль орчин, байгалийн нөөцийнхөө харьцангуй давуу байдалд тулгуурлан нөөц баялгийг нь зохистой ашиглахад зохицсон аж ахуйн уламжлалт болон орчин үеийн нийтлэг хэвшлийг хослуулан хөгжүүлэх замаар байгалийн баялгийг нөхөн сэргээж, төрх байдлыг нь хамгаалж, “НОГООН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР”-ийг хэрэгжүүлж, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.**

**Зорилт: 4.55.** Байгалийн нөөц, түүний нөхөн сэргэх чадвар, хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгмийн дэвшлийг түргэтгэх шаардлагатай уялдуулан дасан зохицох, нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Орчны бохирдлын хэмжээ эрс буурч, хорттой нөхцөл арилна.

Байгалийн нөөц, баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийн асуудлыг орон нутагтаа шийдвэрлэж, жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна. “Ногоон хөгжил” хөтөлбөр боловсруулан ИТХ-аар батлуулж, Булган сумын 800 айл өрхөд бүрэн шаталттай утаа бага гаргадаг зуухыг нийлүүлж, айл өрх, нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдлыг төрөлжүүлэн хийх 2018 ш хогийн савыг байршуулав.

**/Тухайн жил 96,7 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт: 4.56** Ойн нөөцийн менежментийг сайжруулж, мод бэлтгэл, боловсруулалтын дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, барилгын модон материал, түлээг орлох чадвартай шинэ бүтээгдэхүүн бий болгох, орчиндоо зохицсон сайн чанарын үр, суулгацыг тарималжуулах, ойг түймэр, хөнөөлт шавьжнаас урьдчилан сэргийлэх, хамгаалах техник, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

Хүрэх үр дүн: Зохистой хэрэглээ бүхий ойн нөөцийн менежмент сайжирна.

Ой хамгаалах 173 нөхөрлөлтэй болж, өмнөх оноос 3 дахин нэмэгдүүлсний дээр ойн менежментийн төлөвлөгөөтэй боллоо. Ойжуулалтыг 1132,6 га-д, Ойнхортны судалгааны ажлыг 455193 га-д, тэмцлийн ажлыг 70750 га-д хийлээ. Төв суурин газруудад 227934 ширхэг мод, бут тарьж, ногоон байгууламжийг 2 дахин нэмэгдүүллээ.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт: 4.57.** “Цөлжилттэй тэмцэх” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, бэлчээрийг сэлгэж ашиглах, хортон мэрэгчидтэй тэмцэх, усжуулах, талхлагдсан талбайг нөхөн сэргээх, олон наст ургамлын үр тариалах зэргээр байгаль аясаараа нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: “Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр”, “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт хангагдаж, бэлчээрийн менежмент сайжирна.

Уул уурхайн элэгдэж эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг орон нутагтаа шийдвэрлэх эхлэлийг тавьж, Дашинчилэн, Орхон суманд 12,6 га талбайн нөхөн сэргээлт хийсний дээр бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, бэлчээрийг сэлгэн өнжөөх, ашиглалтыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2 дахин нэмэгдэж “Ногоон хэрэм”-ийн туслах зурвасын ажлыг 75,5 га талбайд хийж гүйцэтгэлээ.

**/Тухайн жил 67.1 хувь/**

**/Өссөн дүнгээр 42.1 хувь/**

**Зорилт: 4.58.** Усны нөөцийн чанарын стандартыг хангах, усыг зохистой ашиглах, хамгаалах оновчтой арга, технологийг судалж нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд усны нөөцийг тогтвортой барих нөхцлийг хангаж, иргэд эрүүл ахуйн шаардлага хангахуйц үндны усаар хангагдана.

Усны шинэчилсэн тооллого судалгаатай болж, усны нөөцийг хэмнэх, хаягдал усыг эргүүлэн ашиглах бодлого хэрэгжүүлж байна. Үндны болон бэлчээрийн усан хангамж сайжирч, аймгийн төвийн нэгдсэн усан сан, 10 сумын 21 худагт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулж, иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах ажил эрчимжлээ

**/Тухайн жил 70 хувь/**

**/Өссөн дүнгээр 40 хувь/**

**Зорилт: 4.59.** Байгалийн ургамал, зэрлэг амьтдын удмын санг хамгаалж, боломжтойг нь нөхөн сэргээх замаар үр өгөөжийг нь дээшлүүлж, хүн ам, аж ахуйн хэрэгцээнд зохистой ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: Биологийн төрөл зүйлийн хадгалалт, хамгаалалтын оновчтой механизм бүрдэнэ.

Амьтан, ургамлын тооллого, зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, менежментийн төлөвлөгөөний дагуу тэдгээрийн зохистой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг шинжлэн ухааны үндэслэлтэй зохион байгуулах нөхцлийг бүрдүүллээ.

**/Тухайн жил 93.3 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 4.60.** Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.

Хүрэх үр дүн: Түүх соёлын дурсгалт зүйлс, байгалийн үзэсгэлэнт болон цогцолбор газрууд, ховор амьтан, ургамлын өсөж, үржих таатай нөхцлийг бүрдүүлж, газар нутаг хамгаалагдана.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж баталуулж, Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, шинээр хамгаалалтад авах газар нутгийн судалгааг шинэчлэн гаргав. Аймгийн хэмжээнд нийт газар нутгийн 17.3%-ийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан. Мөн хамгаалалтын захиргаадын ажлын байр, ажилчдын хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдлаа.

**/Тухайн жил 96,7 хувь/**

**/Өссөн дүнгээр 43,3 хувь/**

**Зорилт 4.61.** Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээллийн шуурхай байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна.

Хүрэх үр дүн: Цаг агаарын болон орчны мэдээ мэдээллийг чанарын өндөр түвшинд түргэн шуурхай боловсруулж, түгээх нөхцөл бүрдэнэ.

Цаг уурын мэдээ, мэдээллийг цаг хугацаанд боловсруулж, хэрэглэгчдэд шуурхай түгээх нөхцөл бүрдсэн. Цаг агаарын төлөв байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх талаар мэдээлэл боловсруулж байгаагийн зэрэгцээ сумдтай өдөр бүр мэдээ солилцож, мэдээ, мэдээллийн чанар, таарцын байдалд тогтмол хяналт хяналт тавьж ажиллалаа.

**/Тухайн жил 80 хувь/**

**/Өссөн дүнгээр 65 хувь/**

**Зорилт 4.62.** Газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглах, хот суурины эдэлбэр газруудын харьцааг шаардлагын хэмжээнд зохицуулж, иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Хот суурины эдэлбэр газруудын зохистой харьцаа бий болж, газар ашиглах, эзэмших өмчлөх бодлогыг иргэдийн оролцоотойгоор хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Газар зохион байгуулалтын бодлого, төлөвлөлт хийх ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж хэвшүүлэв. Үүний дүнд газартай холбоотой маргаан багасч, хууль бусаар газар ашиглах байдал эрч багаслаа.

Аймгийн 2014, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдээс ирүүлсэн саналтай уялдуулан боловсрууллаа.

**/Тухайн жил 93,3 хувь/  
/Өссөн дүнгээр 70 хувь/**

**Зорилт 4.63.** Хүнсний аюулгүй байдал хангах нөхцлийг бүрдүүлэх

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2013 оны 01/232 “Нийтээрээ эрсдлээс сэргийлье” аян зохион байгуулах тухай, аймгийн Мэргэжлийн газрын даргын баталсан 01/234 тоот удирдамжинд заагдсаны дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийв. Зөрчил дутагдлыг арилгуулах, сургалт сурталчилгааг өргөн хүрээнд хийснээр баярын өдрүүдэд хоол хүнс тэй холбоотой өвчлөл, гомдол гараагүй байна.

2014 оны 02 дугаар улирлын байдлаар лабораторийн хүчин чадлыг сайжруулах явуулын лабораторийн зориулалтаар нийт 27 төрлийн 70523.2 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж, мөн улсын байцаагчдын хяналт шалгалтын тандалтын багаж 4815,4 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтаар бэлтгээд байна.

Аймгийн Засаг даргын “Шинэ Булган” 2013-2016 оны мөрийн хөтөлбөрийн “Аюулгүй орчинтой Булганчууд” зорилтын 63-т хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сумдад хүнсний аюулгүй байдлын орон тооны бус зөвлөл байгуулан 2013 оны 03 дугаар сарын 01-нээс эхлэн ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчдыг 12 удаагийн сургалтанд хамруулан мэдлэг, чадварыг нь ахиулсан. Байцаагчдад шаардлагатай багаж хэрэгсэл дутагдалтай байгаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 44.4 хувь/**

**Орон нутгийн хамгаалалтанд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.**

**Зорилт 4.64.** Батлан хамгаалах бодлого зорилт, цэргийн шинэчлэлийн бодлогыг сурталчилна.

Хүрэх үр дүн: Батлан хамгаалах багц хууль орон нутагт хэрэгжих нөхцөл бүрдэнэ

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд сумын Засаг дарга нарыг тоо бүртгэлийг явуулах, тайлан мэдээ ирүүлэх чиглэлийг тусгасан зөвлөмж, гарын авлага, сурталчилгааны материалаар бүрэн хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон томоохон ААНБ-ууд үйлчилгээний газруудад сурталчилгааг эрчимтэй явуулсанаар иргэдийн оролцоо сайжирсан. “Монгол цэргийн өдөр” өнөө цагийн Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны ойг аймгийн Засаг даргын батлан хамгаалахын Сайдтай байгуулсан гэрээний дагуу тусгай төлөвлөгөөгөөр тэмдэглэн өнгөрүүлж байна.

Батлан хамгаалахын Сайдтай аймгийн Засаг дарга байгуулсан гэрээний дагуу “Аймгийн стратегийн үнэлгээ” шаардлагатай судалгааны дагуу гаргаж БХЯ-нд хүргүүлж байна.

2014 онд Аймгийн удирдлагууд ИТХ, АЗДТГ-ын ажилтан албан хаагчдыг ЗХ-ны 186-р анги байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа тус ангийн үндсэн чиглэл хугацаат цэргийн албан хаагчдын байрлах орчин, хичээл сургалтын байдал, Зэвсэгт хүчинд хэрэглэгдэж байгаа бүх зэвсэглэл, техник хэрэгсэлүүдийг танилцууллаа. 2014 онд 16 сумын Засаг дарга нарт цэргийн штабын тусгай хөтөлбөрөөр Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар 3 хоногийн сургалт зохион байгуулсан.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 72,2 хувь/**

**Зорилт 4.65.** Төрийн цэргийн бодлогын хүрээнд Батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж албан байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлнэ

Булган аймагт жил бүр цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг ЗХЖШ-ын даргын 2003 оны 1022 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах журам”-ыг үндэслэн явуулж, дүнг нэгтгэж ЗХЖШ-т хүргүүлсэн.

Жил бүр аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс цэргийн насны эрчүүдийн судалгааг гаргуулан авч, тэдгээрийг цэргийн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэх, цэргийн алба хаасан байдалд шалган туслах ажлыг зохион байгуулж илэрсэн дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

Энхийг сахиулах ажиллагааны зорилго, ач холбогдолыг сурталчлах ажлыг зохион байгууллаа. “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдэвт сурталчилгааны ажлыг ЕБС, Хөдөө аж ахуйн болон Боловсролын яамны харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн оюутан сурагч, багш ажилчдыг хамруулан зохион байгууллаа.

“Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдэвт Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Энхийг сахиулах ажиллагааны зорилго, ач холбогдолыг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ын дагуу цэргийн жинхэнэ алба хаах хугацаа дуусч бэлтгэлээр халагдсан иргэдийг Гэрээт цэрэг-Ажлын байр төлөвлөгөөний дагуу гэрээт цэргийн албанд сайн дурын үндсэн дээр элсүүлэх ажлыг зохион байгуулан явуулж Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангиудад иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон шалгаруулалтаар тэнцүүлэн анги байгууллагуудад албыг нь үргэлжлүүлэн хаалгаж байна.

Цэрэг татлагаас санаатайгаар зайлсхийсэн нэр бүхийн 35 иргэнийг аймгийн Засаг даргын захирамжаар тус бүрийг нь 50 мянган төгрөгөөр торгож арга хэмжээ авлаа. Ээлжит цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй эрүүлжүүлэх боломжтой цэргийн насны залуучуудыг албадан эмчилгээнд оруулах ажлыг ЭМГ-тай хамтран зохион байгуулж байна.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэд тухайн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд идвэхтэй оролцож, хүн малын гоц халдварт өвчний үед хорио цээрийн дэглэмийг сахиулахад дэмжлэг үзүүлэх, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зэрэг ажилуудад идэвхитэй оролцож байгуулсан гэрээний дагуу алба хаалгаж байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50хувь/**

***Зорилт 4.66. Иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ.***

*Хүрэх үр дүн: Төрийн цэргийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлсэнээр иргэн-цэргийн харилцааны харилцан ойлголцол гүнзгийрнэ.*

2014 онд Халх голын дайны ялалтын 75 жил, БНМАУ-ын гарамгай баатар Л.Дандарын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан арга хэмжээг зохион байгууллаа.

Халхын голын ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан Булган аймгийн Дашинчилэн сумын харьяат ахмад дайчин Х.Шаравдоржид Монгол улсын ерөнхийлөгчийн зарилгаар цэргийн гавьяаны улаан тугийн одон, ЗГ-аас олгосон 2,0 сая төргөгийг аймгийн Засаг дарга биечлэн гардуулж хүндэтгэл үзүүллээ.

Монгол-АНУ-ын хамтарсан “Хааны-эрэлд” хээрийн сургуулийн хүрээнд Булган сумын Улсын тэргүүний 4-р цэцэрлэгийн дээврийг шинэчлэн засварлах, олон улсын цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг Булган, Хялганат зэрэг сумдад ажиллуулж, аймгийн нийт иргэдийг үнэ төлбөргүй үзлэгт хамруулж, эм бэлдмэл тараан хүмүүнлэгийн ажлыг зохион байгууллаа. Эмнэлгийн үзлэгээр давхардсан тоогоор 3000 орчим иргэд хамрагдлаа.

2014 оны Хаврын тэргүүн сарын сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн ЗДТГ, цэргийн штабын ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, Булган аймгаас хугацаат цэргийн албыг нэр төртэй, үлгэр жишээ хааж байгаа нэр бүхий 10 цэргийн албан хаагчдын ар гэрт нь сар шинийн тавгын идээг гардуулан хүндэтгэл үзүүллээ.

**/Тухайн жил 100 хувь/**



**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 4.67.** Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ

Хүрэх үр дүн: Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

ЗХЖШ-аас ирүүлсэн Зэвсэгт хүчний анги байгууллагуудыг бие бүрэлдэхүүн техникээр нөхөн хангах аймаг, сумдын дайчилгааны төлөвлөгөөг дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний ангитай хамтран жилд 2 удаа тодотгол хийж, холбогдох мэдээ тайланг БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтэсүүдэд хүргүүлэв. Удирдлагын болон цугларах, шилжүүлэх байруудыг төхөөрөмжлөх багаж хэрэгсэлүүдийг дэс дараатай бүрдүүлж байна. Дайчилгааны даалгавар бүхий цэргийн анги байгууллага дээр хагас жилээр тус цэргийн штаб дээр жилийн эцсээр дайчилгааны даалгавараар татан нийлүүлэх бие бүрэлдэхүүн, техникийн тодотголыг бичиг баримтаар тодотгож, материалыг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлж байна.. Мөн 2 дугаар улиралд аймгийн хойд бүсийн 8 сумдад орон нутгийн тодотголыг мөн 4-р улиралд урд бүсийн 8 суманд тодотголыг зохион байгуулж байна.

“Дайчилгааны тухай” Монгол улсын хууль, Батлан хамгаалахын Сайдтай, аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ, 2014 онд 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 40 хүн шинээр мэргэжил эзэмшүүлэх, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 60 хүнд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний 186-р ангийн “Сургалтын төв”-д төвлөрүүлэн зохион байгуулан явуулж шаардлагатай командуудад оногдуулан дансаллаа.

Сургалтыг цэргийн штабын ажилтнууд удирдан зохион байгуулж ЗХ-ний 186-р ангийн зэвсэг, техник, багаж хэрэгсэл үзүүлэн таниулах материалыг түшиглэн тус ангийн мэргэжлийн багш, офицеруудаар хичээл заалгаж, сургалт явуулсан тухай илтгэх хуудсыг БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар хэлтсүүдэд хүргүүлэв.

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт: 4.68.** Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг гүнзгийрүүлнэ.

Хүрэх үр дүн: Тус байгууллагуудын хамтран ажиллах чадавхи дээшилнэ

Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг явуулж уламжлал болгоод байна.

2014 онд Булган суманд ОБГазар зохион байгуулж Тэмцээнд ЗХ-ний 234-р анги, ХЦ-ийн 0286-р анги, Цагдаагийн хэлтэс, ШШГЕГ харьяа хорих 439-р анги, Онцгой байдлын газрын нийт 5 баг байнга оролцож байна.

Энэ үеэр ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүн өөрсдийн анги байгууллагын үйл ажиллагаа, онцлогийн талаар ард иргэдэд товч танилцуулга хийж, анги байгууллагаа сурталчилах ажил тогтмолжлоо.

ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан ажиллагааны төлөвлөгөөтэй хамтран ажиллаж байна.

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт: 4.69.** Хүүхэд залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгоно.

Хүрэх үр дүн: Ард иргэд болон хүүхэд залуучуудын дунд цэрэг, эх орон ч үзэл төлөвшиж, цэргийн алба хаах хүсэл сонирхол нэмэгдэнэ.

Бичиг үсэгт тайлагдаагүй цэргийн насны залуучуудыг бичиг үсэгт тайлах бага боловсролтой иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэх талаар боловсролын газартай хамтран ажиллаж байна. 2014 оны 1,2-р ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй, эрүүлжүүлэх эмчлэгдэх боломжтой цэргийн насны 6 залууг албадан эмчилгээнд оруулах ажлыг ЭМГ-тай хамтран зохион байгуулж, хугацаат цэргийн албанд тэнцүүлэн алба хаалгаж байна.

2014 онд БХИС-ийн Ерөнхий зориулалтын дээд сургуульд 5, Ахлагчийн сургуульд 9 хүүхдийг элсүүлэн суралцуулж байна. Цэргийн штаб, БГ-тай хамтран МСҮ Төвүүд болон ЕБС-ийн ахлах ангийн сурлагчидтай Батлан хамгаалах бодлого

зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, өнөөгийн хөгжил, энхийг сахиулах ажиллагааны талаарх танилцуулга хийн сонирхолтой бичлэг баримтад кино үзүүлж сурагчдад эх оронч үзэл, хүмүүжлийн талаар уулзалт ярилцлага, АХА тэмцээн зохион байгуулж 18 нас хүрсэн хүүхдүүдэд Цэргийн үүрэгтний үнэмлэх гардууллаа.

**Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 4.70.** Улсын хил хамгаалалтанд дэмжлэг үзүүлнэ.

Хүрэх үр дүн: Улсын хилийн халдашгүй дархан байдал хангагдаж, тус бүс нутгийн ард иргэдийн аюулгүй, тайван амьдрах орчин бий болно.

Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0286-р ангийн удирдлагуудын тодорхойлолтыг үндэслэн тэргүүний хилчин офицер-2, ахлагч-2, энгийн ажилчин-2 хүнийг аймгийн Засаг даргын жуух бичиг, 50000 төгрөгөөр шагнаж урамшуулсан. Монгол Улсын хилийн дагуу орших Булган аймгийн Сэлэнгэ, Тэшиг сумдад цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй 10 гаруй иргэдтэй Цэргийн штаб, хил хамгаалах байгууллага гурвалсан гэрээ байгуулан улсын хил хамгаалалтанд туслах хүчний гишүүний үүргийг гүйцэтгүүлж байна. Цэргийн алба хаасан 4 иргэнийг ХЦ-ийн 0243-р ангид, 6 иргэнийг 0286-р ангид гэрээт хилчиний албанд элсүүлэн анги байгууллагуудад албыг нь үргэлжлүүлэн хаалгаж байна.

*Хилийн албаны үйл ажиллагааг орон нутгаас дэмжиж хамтран ажилласнаар хилийн болон хил орчмийн дэглэмжийн зөрчилгүй тайван байна.*

**Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 4.71** Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг арилгах ажлыг сайжруулж, гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн: Гамшиг ослоос хамгаалах чадавхи сайжирна

Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулахын тулд аймгийн Засаг даргаас баримтлан хэрэгжүүлэх Булган аймгийн 2014-2024 онд 2 үе шаттай “Гамшгаас хамгаалах дэд хөтөлбөр”, “Гамшгаас хамгаалах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан 03-р сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Иргэдийг чадавхижуулах чиглэлээр:

Олон нийтэд тулгуурласан гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Говийн баавгай” сэдэвт Газар хөдлөлт, анхны тусламжийн сургалтанд тус газраас 3 алба хаагч хамрагдан үндэсний сургагч багшаар бэлтгэж 10 дугаар сард 16 суманд ДЗОУБ-тай хамтран Газар хөдлөлт, анхны тусламжийн сургалтыг 900 гаруй иргэдэд, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын 5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд сумд, байгууллага, аж ахуйн нэгжид зарлан мэдээллийн нэгдсэн дохиогоор ажиллуулахаар аймгийн Засаг даргын А\132 тоот захирамж, авах арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын 2014 оны 01\326, 327 тоот албан бичиг, заавар зөвлөмжийн хамт 16 сум, 1 тосгон, 76 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, алба хаагчдыг хуваарилан биелэлтийг нь хангуулан МСҮ-ийн төвд газар хөдлөлтийн үед авах арга хэмжээний хамтарсан дадлага сургууль зохион байгуулахаар зохион байгуулалтын ажлуудыг хийж 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 16 цагт аймгийн хэмжээнд зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллуулж 250 байгууллага, аж ахуй нэгж, 25 автомашин, 8000 гаруй хүн оролцож үзүүлэх сургуулийг Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд Цагдаагийн газар, Нэгдсэн эмнлэгтэй хамтран тус тус зохион байгуулж хамруулсанаар болзошгүй газар хөдлөлтийн аюулын үед орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхи сайжирсан.

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ангиллын сургалтын хөтөлбөрийг батлан хүргүүлсэний дагуу сумдын орон тооны бус штаб, мэргэжлийн анги, иргэд, оюутан сурагчдын ангиллаар 04-р сарын 16-наас 2 ажлын хэсгийг 16 сумдад ажиллуулж мэргэжлийн анги болон иргэдэд, нийт 96 цагийн сургалтыг 1710 хүнд зохион байгуулсан байна.

Дэлхийн зөн ОУБ-тай “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдлийг бууруулах” хөтөлбөрийн сургалтыг аймгийн бүх сумдад хийхээр төлөвлөн Булган сумын 1, 6-р багийн 57 хүнд газар хөдлөлтийн чиглэлээр сургалт хийгдлээ. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Дэлхийн зөн ОУБ-ын БХНХХ, БНХХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран ажиллах төлөвлөгөө гарган батлуулж, Дэлхийн Зөнгийн байранд хүүхэд, өсвөр үеийнхэнийг аюулгүй амьдрах ухаанд сургах зорилгоор “Аюулгүй амьдрах төв”-ийг байгуулан уг төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулж сар бүр ажил зохион байгуулж байна.

Удирдах бүрэлдэхүүнийг чадавхижуулах чиглэлээр

2014 оны 02-р сард аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн гамшгаас хамгаалах 12 албадыг нэмэгдүүлж 14 алба, сумдад 32 албыг шинээр, сумдын мэргэжлийн ангиудыг шинэ дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулж, 04-р сард сумын 17 гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилэн тодотгож 01, 02 дугаар сард сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, Тамгын газрын дарга нарт 2014 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар сургалт, танилцуулга хүргүүлсэн.

10-р сарын 27-29-ны өдөр Бугат суманд Эүүл мэндийн газар, Үйлдвэр хөдөө аж ахуйн Мал эмнэлгийн хэлтэстэй хамтран “Болзошгүй гамшгийн үед нутгийн удирдлагын үйл ажиллагаа” сэдвээр гамшгаас хамгаалах сургуулийг зохион байгуулж энэ үеэр 66 хүний бүрэлдэхүүнтэй Мэргэжлийн ангийг газар хөдлөлтийн үеийн аврах ажиллагааны дадлага сургууль, удирдах бүрэлдэхүүнд газар хөдлөлт сэдвээр цагийн байдал өгч ажиллууллаа. 11-р сарын 04-06-ны өдрүүдэд мөн Хангал суманд “Гамшиг ослын үед сумын гамшгаас хамгаалах штабын үйл ажиллагаа” сэдвээр гамшгаас хамгаалах сургуулийг зохион байгуулж сургуулийн өдрүүдэд сумыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаа.

Аврах, ажиллагааны техник, багаж зэвсэглэмжийн чадавхи

13 суманд объектын болон ой, хээрийн гал түймрийг унтраах зориулалттай мотопомп, хоолой хошуу авахаар хөрөнгийг шийдвэрлэн 13 суманд мотопомп иж бүрдлийн хамт, гал унтраах багаж зэвсэглэмжээр хангаж, орон нутгаас өөрсдөөр нь дулаан байр, усны савыг бэлтгүүлэх ажил зохион байгуулсан. ДЗОУБ-аас 12 сая төгрөгний хөрөнгийн дэмжлэг үзүүлж 10 суманд объектын галын гар багаж, хөдөлмөр хамгааллын хувцасыг өгч 04-р сард ОБГ-аас сумдад ажиллаж бэлэн байдлыг хангууллаа.

Зарлан мэдээллийн дуут дохиог сумдад суурьлуулахаар 2014 оны аймаг, сумын Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байна. 11-р сарын байдлаар Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Булган, Бугат, Хутаг-Өндөр, Хангал зэрэг 9 сум буюу 50 хувь нь суурьлуулаад байна.

Мөн тус аймагт ажилласан Солонгосын компанид энэ чиглэлээр хандаж тус аймгийн төвд газар хөдлөлийн аюулыг амжиж мэдээлэх системийг суурилуулж өгөх боломж байгаа талаар тохиролцон 08-р сард 162 сая төгрөгний өртөгтэй зарлан мэдээллийн тоног төхөөрөмж өгөгдлөө.

Онцгой байдлын газарт 30 ширхэг үүргийн ус шүршигчийг ОБЕГ-аас хангалаа.

Хөтөлбөрийн хэрэгжилт 2014 онд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу энэ жил 99 хувьтай, өссөн дүнгээр 52 хувьтай хэрэгжүүллээ.

**/Тухайн жил 98.0 хувь/  
/Өссөн дүнгээр 58 хувь/**

**Зорилт 4.72** Гадаад харилцааг эдийн засагжуулах, хил залгаа, уламжлалт харилцаатай болон шинээр хөрш орнуудтай харилцаа тогтоож найрсаг харилцааг үргэлжлүүлж, харилцан ашигтай түншлэлийг бататган бэхжүүлнэ.

Хүрэх үр дүн: Уламжлалт харилцаа өргөжиж, гадаад харилцаа эдийн засагжиж, нутгийн зөвлөлүүдийн хамтын ажиллагаа өргөжсөн байна

Уламжлалт харилцаатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ОХУ, АНУ, Вьетнам, Япон, БНСУ, БНХАУ, Энэтхэг улсуудтай төрийн захиргаа, нийгэм, эдийн засаг, бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллалаа.

Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн уулзалтыг зохион байгуулснаар нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжсэн.

Цаашид Монгол услын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд Япон, Солонгос, БНХАУ-тай байгуулсан

хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, сум, агентлаг, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулах, гадаад орнуудад суугаа элчин сайдаар болон бусад сувгаар дамжуулан улс орнуудтай харилцаа тогтоох боломжуудыг судлан хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Мөн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 134-р тотгоолоор батлагдсан “Булган аймагт аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр”-т гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтыг тусгаад байна.

**/Тухайн жил 85 хувь/  
/Өссөн дүнгээр 41,75 хувь/**

**Хууль дээдлэн, гэмт хэргийн гаралтыг бууруулан хүн бүр эрх тэгш, аюулгүй амар тайван орчинд амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллана.**

**Зорилт: 4.73** Хууль зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ

Хүрэх үр дүн: Иргэдэд хууль зүйн тусламж үйлчилгээг авах боломж нэмэгдэн, хүний эрхийн шаардлага стандарт хангагдана.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэ төлбөргүй өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуй нэгж байгууллагад хууль зүйн зөвлөгөө өгөх ажил тогтмол хийгдэж байгаа бөгөөд аймгийн төвөөс алслагдсан сум, багт ажиллаж, амьдарч байгаа иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Иргэдийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрөөр сум бүрт эрх зүйн мэргэжилтэй “Иргэдийн эрх зүйн хөтөч” ажиллах шаардлагатай байгаа тул мэргэжлийн боловсон хүчнээс шалтгаалан удаашралтай байна.

Цагдан хорих, баривчлах болон албадан саатуулах байрны нөхцөлийг хүний эрхийн стандартад нийцүүлэх зорилгоор улсын болон олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагын дэмжлэгээр үе шаттай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж ажилласнаар хүний эрхийн сатандартад нийцсэн цагдан хорих байртай болсон. Баривчлах болон албадан саатуулах байрны нөхцлийг сайжруулах ажлыг байгууллагын нөөц бололцоогоор тогтмол хангаж байна.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 47,8 хувь/**

**Зорилт: 4.74.** Хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Хүрэх үр дүн: Хуулийн байгууллагын ажилтан, албан хаагчид ажиллах нөхцөлөөр бүрэн хангагдана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны конторын барилга, Цагдаагийн албан хаагчдын 30 айлын орон сууцны барилгууд ашиглалтанд орж, дараагийн ээлжинд Төрийн албан хаагчдын 30 айлын орон сууц, ШШГА-ны 24 айлын орон сууцны барилгууд баригдаж эхлээд байна. Сумдад ажиллаж буй хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг унаажуулах, ар гэрийг ажлын байраар хангах, Цагдаагийн газрын алба хаагчдыг зөөврийн компьютер, дагалдах техник хэрэгсэлтэй болоход дэмжих ажил үе шаттай хийгдэж, хэсгийн төлөөлөгч нарын гэр бүлийн 90 хувь нь ажлын байраар хангагдаад байна. Төрийн архивын байрыг стандартад нийцүүлж засварлах ажил Аймгийн Засаг даргын Тамгын газар шинэ конторын барилгадаа шилжиж орохоор шийдвэрлэгдэхтэй холбоотойгоор удаашралтай байна.

Цагдаагийн алба хаагчдын 2 давхар орон сууцны гадна пасад сантехникийн засварын ажлыг хийсэн бөгөөд уг орон сууцны их засварын ажил, Улсын бүртгэлийн хэлтсийн конторын шинэ барилга барих ажлын газар олголт, зураг төсөв хийх зэрэг ажлуудыг бэлэн болгож хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

**/Тухайн жил 76,6 хувь /  
/Өссөн дүнгээр 61,6 хувь/**

**Зорилт: 4.75 “Архигүй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аюулгүй амгалан орчин бүрдүүлнэ.**

Хүрэх үр дүн: Гэмт хэрэг, зөрчил буурч, амар тайван орчин бүрдэнэ

“Архигүй Булган” хөтөлбөрийн 2014 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 3 удаа хэлэлцүүлснээр 2014 оны төлөвлөгөөг батлаж, 25 сая төгрөгний төсөв батлан, тодорхой ажлууд хийгдэж байгаагаас гадна Архи,

согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх, тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд Аттестатчилал хийх зорилгор Аймгийн Засаг даргын 2014 оны А/370 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд аттестатчилал хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд оруулахад бэлэн болоод байна.

Хөтөлбөрийн хүрээнд албадан болон сайн дурын эмчилгээний хөтөлбөрүүд хэрэгжиж нийт 50 гаруй хүн хамрагдаж, сум, байгууллагуудад сургалт зохион байгуулаад байна.

“Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан ажиллаж байна.

**/Тухайн жил 90.0 хувь /  
/Өссөн дүнгээр 47,5 хувь**

**Зорилт: 4.76** Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдэж, шударга бус өрсөлдөөнд тавих хяналтыг бүрдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/86 дугаар захирамжаар “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” дэд хөтөлбөрийг баталж, 2014 онд 1 сая төгрөгний санхүүжилт олгов. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлэн удирдамжийн дагуу жолооны сургалтын төвүүдийн аттестатчилал явуулсан. Сургалтын төвүүдийн үйл ажиллагаа, сургалтын машин техникийн стандартын шаардлага аюулгүй ажиллагааны асуудлаар зөвлөмж өгсөн. Хэрэглэгчдийн санал бодол, гомдлыг хүлээн авах 70343411 дугаарыг нээн ажиллуулж байна.

**/Тухайн жил 80 хувь/  
/Өссөн дүнгээр 42.5 хувь/**

**Зорилт 4.77** Нийгмийн дэг журмыг хангахад орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Нийгмийн дэг журам хангах орчин үеийн стандарт хангасан техник хэрэгслээр хангагдсан байна.

Аймгийн төвийн 36 цэгт 86 камерийг байрлуулах ажлыг 583,0 сая төгрөгөөр, томоохон голуудын гүүрэн гарцуудыг байгаль хамгаалах сангийн 350,4 сая төгрөгөөр, Зоон давааны Зам тээвэрийн хяналтын төвийг 144 сая төгрөгөөр барин ашиглалтанд хүлээж аваад байна.

Булган сумын төв, Рашаант сумын сум дундын цагдаагийн тасагт хөдөлгөөнт эргүүлийн бүрэн тоноглогдсон 4 ширхэг шинэ автомашиныг орон нутгийн хөгжлийн сангийн 66,0 сая төгрөгөөг шийдвэрлэн ашиглаж байна.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 90 хувь/**

**Зорилт 4.78** Үндсэн хуулиар заасан иргэний үүргийн хэрэгжилтийг хангуулна.

Хүрэх үр дүн: Иргэний үүргийн хэрэгжилт сайжирснаар иргэдийн эрх хангагдана.

Уг ажлын хүрээнд сумдад болон хэлтэс агентлагуудад тогтмол сургалт хийж байна. Энэ оны 1 дүгээр улиралд Аймгийн Хуулийн байгууллагууд /Сум дундын 4 дүгээр шүүх, Прокурорын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс/ 16 сум, 1 тосгонд үйл ажиллагааны тайлангаа тавих үеэр иргэний үндсэн болон журамт үүргийн талаарх сургалтыг хийсэн.

Мөн шууд ардчиллыг хөгжүүлэх зорилгоор аймаг, сум бүрт Иргэний танхим байгуулан, аймгийн Засаг даргын дэргэд Олон нийт, иргэдтэй харилцах албыг байгуулан иргэний танхим хариуцсан ажилтанг томилон ажиллаж байна.

**/Тухайн жил 86,6 хувь/  
/Өссөн дүнгээр 46,6 хувь/**

#### **ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛТАЙ БУЛГАНЧУУД**

**Ил тод нээлттэй тунгалаг, хариуцлагатай, хяналттай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ.**

**Зорилт: 5.79.** Төрийн үйлчилгээг “Нэг цонх”-ны зарчимд шилжүүлнэ

Хүрэх үр дүн: Төрийн үйлчилгээг нэг цэгээс хөнгөн шуурхай чирэгдэлгүй хүргэнэ

Баяннуур, Бугат, Гурванбулаг, Хутаг–Өндөр Дашинчилэн, Тэшиг, Бүрэгхангай, Рашаант, Могод, Орхон, Сэлэнгэ сумд “Нэг цонх, нэг цэгийн зарчим”-д шилжиж, 7 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

Мөн ихэнх сумд “Угтах үйлчилгээ”, “Нүүдлийн Тамгын газар”, “Мэдээллийн богц” зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэн, сургалт сурталчилгааг зохион байгуулж, мэдээлэл өгч, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч нутгийн удирдлагын бодлого, шийдвэрт тусгуулах арга хэмжээ авч ажилладаг нь хэвшил болсон.

Булган сумын “Нэг цонх”-оор үйлчлүүлсэн хүний тоог өмнөх жилийн 3 дугаар улирлын мөн үетэй харьцуулахад 6,3 хувиар өссөн байна.

**/Тухайн жил 95.0 хувь/  
/Өссөн дүнгээр 48.0 хувь/**

**Зорилт: 5.80.** Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлж, байгууллагын чадавхийг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдын мэдлэг үр чадвар хариуцлага, ажиллах нөхцөл сайжирснаар төрийн байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө дээшилнэ

Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчдад чадваржуулах сургалтыг шат дараатайгаар зохион байгуулснаар мэдлэг үр чадвар сайжирч төрийн албаны үйл ажиллагааны үр дүн сайжирч байна.

Цагдаагийн газар, Онцгой байдлын газар зэрэг төрийн байгууллагууд албан хаагчдын орон сууцнуудыг шинээр барьж ашиглалтанд оруулж эхлээд байгаа нь төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын томоохон үзүүлэлт болж байна.

Сэлэнгэ суманд сумын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг анх удаа зохион байгуулж сумын төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батласан нь шинэлэг ажил болсон байна.

Багийн засаг даргын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласнаар ажиллах нөхцөл боломж болон мэдлэг чадвар дээшилж хууль эрх зүйн хүрээнд иргэдэд анхан шатны мэдээлэл хүргэх ажил дээшиллээ. Мөн сумдын ЗДТГ-ын байруудыг шинэчлэхтэй холбоотой судалгаа хийснээр нөхцөл байдлын дүгнэлтэнд хүрч ажиллаж байна.

**/Тухайн жил 97.5 хувь/  
/Өссөн дүнгээр 48.75 хувь/**

**Зорилт 5.81.** Төрийн ажил үйлчилгээний чанар үр дүнг иргэдийн оролцоотой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх журмыг өөрчилсөнөөр иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангасан үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/477 дугаар захирамжаар “Орон нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний журам”-ыг батлан мөрдөж ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагын оролцоотой үнэлүүлэх бодлого баримталж, 2014 оны үйл ажиллагааны тайлангийн хэрэглэгчийн үнэлгээг аймгийн залуучуудын холбоогоор гүйцэтгүүлж байна.

Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний журам, аймгийн Засаг даргын “Шинэ Булган” хөтөлбөрийг хэрэгжилтийг тооцож мэдээлэх талаар тусгайлсан гарын авлага бэлтгэн суманд хүргүүллээ. Хяналт шинжилгээ үнэлгээний хугацаатай мэдээ, тайлангуудыг цахим хэлбэрээр авч хэвшиж мэдээллийн хугацааг цахимаар ирүүлсэн байдлаар бүртгэн албажуулж байна. Булган сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг олон нийтээр хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдийн саналыг авлаа. Хэрэглэгчийн үнэлгээний асуулгыг аймгийн цахим хаягт байршуулан санал авч байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн үнэлгээ, бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгээр үнэлэх тогтолцоо бүрдэж, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал, засаглалын үр өгөөжөөр үнэлэх зарчимд шилжиж байна.

**/Тухайн жил 95.0 хувь/  
/Өссөн дүнгээр 47,9 хувь/**

**Зорилт: 5.82.** Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

Хүрэх үр дүн: Нийтийн албан хаагчдын дунд авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл буурна.

Аймгийн хэмжээнд бүх шатны төрийн байгууллагууд Авлигатай тэмцэх, шударга ёсыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллаж байна. Жил бүрийн 2 дугаар сард албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг бичгээр болон цахим хэлбэрээр гаргуулан авч, нэгтгэн Авилгатай тэмцэх газар хуулийн хугацаанд хүргүүлж байна.

Сум, байгууллагын 40 эрх бүхий албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан бүсийн суралтанд хамруулж, ХАСХОМ бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар арга зүйн зөвлөмж өглөө.

Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай А/439 дугаар захирамж гарган сум, байгууллагын дарга нарт үүрэг өглөө.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

**Зорилт 5.83.** Мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахуйц өрсөлдөөнт хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн. Мэдээллийн ил тод байдал, хүртээмж сайжирна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд, цахим үйлчилгээг өргөн ашиглах замаар болон улс, аймаг, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг түгээн, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай нээлттэй хүргэж байна.

**/Тухайн жил 90.0 хувь/  
/Өссөн дүнгээр 42.0 хувь/**

**Зорилт: 5.84.** Цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал хангагдаж, иргэд үнэн зөв, цаг үеийн мэдээлэл олж авах боломж нэмэгдэнэ.

Төрийн үйлчилгээний “ТҮЦ” машин, хөдөлмөрийн “Е бирж ашиглалтад орсноор иргэд мэдээллийг хурдан шуурхай авах боломжоор хангагдсанаас гадна Цагдаагийн газар, Булган, Бугат, Орхон сумд болон ихэнх сумдын багийн хэсгийн ахлагч нар мобигетэр буюу мессежээр мэдээ, мэдээллийг иргэддээ цаг алдалгүй шуурхай хүргэж байна.

Түүнчлэн байгууллагууд өөрсдийн цахим [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) веб хуудсыг шинэчлэн ажиллаж байгаагаас гадна. Аймгийн Шүүхийн [www.bulgan.court.gov.mn](http://www.bulgan.court.gov.mn), Прокурорын газрын [www.bulganpro.mn](http://www.bulganpro.mn), Цагдаагийн газрын [www.bulgan.police.gov.mn](http://www.bulgan.police.gov.mn), Улсын бүртгэлийн хэлтэс [www.burtgel.mn](http://www.burtgel.mn) хаягтай болж, байгууллагынхаа үйл ажиллагааг иргэдэд цахим хэлбэрээр тогтмол хүргэж байна.

Мөн байгууллага, сумд өөрсдийн “Fase” хуудастай болж, мэдээ мэдээллээ байршуулж байна. Сэлэнгэ, Дашинчилэн, ҮХААГ, БОГ, Баян-Агт, Бугат, Баяннуур, Булган, Орхон, сумд шинээр сумын вэб сайттай болсон.

**/Тухайн жил 95.0 хувь/  
/Өссөн дүнгээр 47.5 хувь/**

**Аймаг сумын хурал, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явц, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн ил тод байдал, түүнд иргэд тэгш оролцох боломжийг хангаж тунгалагжуулна.**

**Зорилт: 5.85.** Шууд ардчиллыг бэхжүүлж, иргэддээ нээлттэй, иргэдийн оролцоотой асуудлаа, шийддэг байх эрх зүйн орчинг бий болгож, сумын дүрэмтэй болгоно.

Хүрэх үр дүн. Орон нутгийн засаглал дахь иргэдийн оролцоо нэмэгдэнэ

Орон нутгийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангах аргуудыг нэвтрүүлж хэвшүүлэн, шийдвэр гаргахын өмнө иргэний танхимаар дамжуулан хэлэлцүүлэх, хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ өгөх, хяналт тавих

ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах бодлого барьж, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, үр дүнд хүргэн ажиллаж байна.

**/Тухайн жил 90.0 хувь/  
/Өссөн дүнгээр 43.8 хувь/**

**Зорилт: 5.86.** Аймаг сумын хурал, захиргааны байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын үр ашигтай түншлэлийг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Орон нутгийн хөгжлийн талаарх асуудлыг шийдвэрлэхэд иргэд, ИНБ-ын идэвх оролцоо нэмэгдэнэ

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл-2014” форумаас төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын үйл ажиллагаа, түншлэлийн талаарх шийдвэрийн төсөл, зөвлөмж, хамтран ажиллах хөтөлбөр, төлөвлөгөө, Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болох ажлын үлгэрчилсэн жагсаалтыг гарган, түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж байна.

**/Тухайн жил 100.0 хувь/  
/Өссөн дүнгээр 50.0 хувь/**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**